

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-36
1.Монголбанкны 2024 оны санхүүгийн тайлан	4-36

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
06 дугаар сарын 03-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 52 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга;
Тасалсан: Р.Батболд, Н.Батсүмбэрэл, Ш.Бямбасүрэн, Х.Ганхуяг,
Б.Мөнхсоёл, П.Сайнзориг, О.Цогтгэрэл.

Нэг.Монголбанкны 2024 оны санхүүгийн тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, мөн банкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, Санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин, Судалгаа, статистикийн газрын захирал Д.Даваасүх, Хяналт шалгалтын газрын захирал Ц.Нарандалай, Хяналтын зөвлөлийн дарга Н.Ууганбаатар, Мөнгөний бодлогын хорооны гишүүн Р.Даваадорж, Н.Батнасан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Монголбанкны 2024 оны санхүүгийн тайланг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Монголбанкны Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийг Хяналтын зөвлөлийн дарга Н.Ууганбаатар нар танилцуулав.

Тайлан, санал, зөвлөмжтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа, Д.Энхтүвшин, М.Бадамсүрэн, О.Батнайрамдал, Ж.Алдаржавхлан, Б.Жаргалан, Л.Соронзонболд, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Монголбанкны

Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Хяналтын зөвлөлийн дарга Н.Ууганбаатар, Мөнгөний бодлогын хорооны гишүүн Н.Батнасан, Р.Даваадорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, М.Бадамсүрэн, Ж.Алдаржавхлан, Л.Соронзонболд нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн Монголбанкн дахь Ирээдүйн өв сангийн валют болон тус банкны Төрийн сангийн данс дахь Хуримтлалын сан, Хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, гүйцэтгэл болон Үндэсний баялгийн сангийн хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцаж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан Ипотекийн зээлийн хэрэгжилтийг хянан шалгах ажлын хэсэг байгуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүд Монголбанкны 2024 оны санхүүгийн тайланг хэлэлцлээ.

Уг асуудлыг 16 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 51 минут үргэлжилж, 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 43 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
14 цаг 52 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн, Батнайрамдал, Батчимэг, Батшугар, Ганбаатар, Лодойсамбуу, Мандхай, Найдалаа, Сэддорж, Ундраа, Цэнгүүн, Энхтүвшин, Энхцэцэг нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. 2 гишүүн чөлөөтэй. Мөнхсоёл, Батболд, Бямбасүрэн 3 гишүүн юм байна. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал 1.Монголбанкны 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан болон Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмж.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу?

Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудал Монголбанкны 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан болон Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсэг ирсэн байна. Монголбанкны санхүүгийн тайлангийн танилцуулгыг Монголбанкны Ерөнхийлөгч Лхагвасүрэн хийнэ. Микрофоныг нээе ажлын хэсгийн 3 номер.

Б.Лхагвасүрэн: Эрхэм хүндэт Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороон дарга, гишүүд та бүхний энэ өдрийн амар амгаланг мэндчилье.

Монголбанкны зүгээс 2024 онд авч ирүүлсэн бодлого, үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн талаар товч мэдээлэл хүргэе.

Монгол Улс цар тахал, геополитикийн хурцадмал нөхцөл байдлаар даамжирсан эдийн засгийн хүндрэлүүдийг амжилттай даван туулж өнгөрсөн он, 2 жилийн хугацаанд эдийн засаг бүрэн сэргэлээ гэж Төв банкны зүгээс харж байгаа. Хэдийгээр бүрэн сэргэж байгаа хэдий ч гадаад орчны тодорхой бус байдал бас туйлын өндөр хэвээр байгаа. Тиймээс 2024 оны эдийн засгийн гүйцэтгэлийг цаашид тогтвортой хадгалах нь бидний хувьд бас томоохон сорилт хэвээр ингээд үргэлжилж байна.

Энэхүү нөхцөл байдалтай уялдуулан Монголбанк дотоодын эдийн засагт бодлогын тохируулга хийн ажиллаж ирлээ. Манай улсын эдийн засаг 2023-24 онд зудын хүндрэлтэй нүүр тулж, хөдөө аж ахуйн салбар 2 жил дараалан ийм агшсан байгаа. Үүнээс үндэс шалтгаалан малчдын зээлийн эргэн төлөлт доголдох, мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл буурах, эдийн засгийн өсөлт саарах эрсдэл үүссэн. Энэ хүндрэлийг зөөлрүүлэх малчдын төлбөрийн эрсдэлийг бууруулах зорилгоор Монголбанк 2024 онд бодлогын хүүг үе шаттайгаар ингээд 3 удаа бууруулж, 10 хувьд бас хүргэн ажилласан байгаа.

Мөн түүнчлэн эргэн төлөлт доголдсон малчдын зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах арга хэмжээг бас авч хэрэгжүүлсэн. Сүүлийн жилүүдэд хэрэгжүүлсэн мөнгөний хатуу бодлого үр дүнгээ ө өгч инфляц 2024 оны туршид Төв банкны зорилтот интервалд хадгалагдаж ирсэн нь эдийн засаг санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлсэн байгаа болно.

Гадаад эрэлтийн таатай нөхцөл байдал үргэлжилж, экспортын орлого нэмэгдэж байсан таатай боломжийг ашиглан гадаад валютын улсын нөөцийг 2024 онд түүхэн дээд хэмжээ буюу 5.5 тэрбум долларт хүргэж ажиллалаа.

Мөн цаашлаад Монголбанк, Хятадын Ардын банкны хооронд байгуулсан үндэсний мөнгөн тэмдэгт своп, үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн гэрээний ашиглалтын үлдэгдлийг 2 дахин бууруулж, гадаад өрийн дарамтыг мөн багасгасан байгаа.

Эдийн засаг тогтворжиж гадаад төлбөрийн чадвар сайжран инфляц зорилтот түвшинд буурсныг олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагуудыг эергээр үнэлж, Монгол Улсын зээлжих зэрэглэлийг В+ түвшинд хүргэн ингээд 1 шатаар ахиулсан. Засгийн газар болон хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүд болон олон улсын санхүүгийн зах зээлээс таатай нөхцөлөөр өртөг багатай санхүүжилт татах боломжийг ингээд бүрдүүлж ажиллалаа. Банкны салбарын тогтвортой байдлыг хангах, банкнуудын засаглалыг сайжруулах, эрсдэлийг даах чадварыг нэмэгдүүлэх хүрээнд Монголбанк банкны хяналт шалгалтын бодлого зохицуулалтын орчныг тасралтгүй сайжруулан ажиллаж байна. Үүний үр дүнд банкны салбарын актив хөрөнгө 2024 оны эцсийн байдлаар 25.1 хувь буюу 14.3 их наяд төгрөгөөр өсөж, нийт активын хэмжээ 71.4 их наяд төгрөгт хүрсэн болно.

Мөн чанаргүй зээлийн хувь хэмжээ 4.4 хувь буюу 2015 оноос хойших хамгийн бага түвшинд мөн хүрсэн байгаа. Монголбанк цахим төлбөр тооцооны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд бас мөн онцгойлон анхаарч ажиллаж ирлээ.

Үүний жишээ нь олон улсын стандарт шаардлагыг хангасан аппл пей/Apple pay/ үйлчилгээг амжилттай нэвтрүүлж, Монгол Улс цахим төлбөрийн эко системийг шинэ түвшинд хүргэх энэ эхлэлийг тавьсан байгаа. Зээлийн мэдээллийн шинэчилсэн стандарт, зээлийн онооны тогтолцоог нэвтрүүлэх чиглэлд зээлийн мэдээ үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай хамтран олон улсад нэлээн түгээмэл хэрэглэдэг FICO зээлийн онооны системийг Монгол Улсад анх удаа нэвтрүүлэн ажиллаж байна. Ингэснээр зээлийн эрсдэлийн зардлыг хавтгайруулан зээлийн хүүд шингээдэг бус зээлдэгчийн зээлдэгч бүрийн онооноос хамаарч зээлийн хүү ялгавартай тогтоодог шинэ тогтолцоонд шилжих ажлыг ингээд Монголбанкны зүгээс бодлогоор дэмжин ажиллалаа.

Цаашид эдийн засаг санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зуучлалын хэвийн үйл ажиллагааг хангах, цаашид үр ашгийг нэмэгдүүлэх хүрээнд Монголбанк бодлого, үйл ажиллагаагаа тууштай ингээд чиглүүлэн ажиллаж байна. Мөн өнөөдрийн энэ үйл ажиллагааны тайлантайгаа хамт санхүүгийн тайлангаа бас танилцуулж байгаа. 2024 оны 12 сарын 31-ний энэ эцсийн энэ санхүүгийн тайланг олон улсын аудитын нэр бүхий 4 компанийн нэг болох “Пи Даблью Си”/PwC/ компани ингээд баталгаажуулсан байгаа. Тэгээд Монголбанк 2024 онд манай санхүүгийн тайлан ашигтай гарсан сүүлийн хэдэн жил анх удаагаа. Тэгээд Монголбанкны алдагдлыг 300 тэрбум төгрөгөөр бууруулсан ийм санхүүгийн тайлан гарсан байгаа. Товчхон танилцуулахад ийм байна.

Р.Сэддорж: Монголбанкны Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийг Хяналтын зөвлөлийн дарга Ууганбаатар танилцуулна. 5 номер.

Ууганбаатар: Гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Хяналтын зөвлөлийн дарга Ууганбаатар. Монголбанкны 24 оны аудитын санхүүгийн тайлан болон хараат бус аудитын тайланд өгөх дүгнэлт гэсэн ийм зүйл байгаа. Энийг би товчхон танилцуулъя.

Нэгдүгээрт тайлан, түүний баталгаажуулсан байдлын тухайд гэвэл Монголбанк бол жилийн санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 16 болон санхүүгийн тайлагналын олон улсын стандарт 9-ийг баримтлан боловсруулаад “Пи Даблью Си”/PwC/ Аудит ХК-аар хөндлөнгийн аудит хийлгэн баталгаажуулсан байна. Энд бол хуульд заасан шаардлагыг хангасан гэж үзэж байгаа. Хараат бус аудитор бол хязгаарлалттай дүгнэлт өгсөн. Хязгаарлалттай дүгнэлтийн талаар бид хараат бус аудитортой болон Монголбанкны удирдлагатай уулзсан. Хязгаарлалттай дүгнэлт өгсөн шалтгаан нь бол 18 онд Монголбанкны хөндлөнгийн үнэлгээ хийлгэж Эрдэнэсийн санд хөрөнгөөр бүртгэсэн 1925 оны ийм зэс болон мөнгөн зоостой холбоотой. Хөндлөнгийн аудитын байгууллага бол эдгээр зоосыг хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэх эсэх дээр хангалттай нотолгоо олж авч чадаагүй. Тэгээд дээрээс нь үнэлгээ бол бодит үнэ цэнээр бус гэсэн ийм шалтгаанаар 18 оноос хойш хязгаарлалттай дүгнэлт өгсөөр ирсэн байгаа. Монголбанкны удирдлага бол энэ дээр, энэ зоосыг бол 38 онд бол бүрэн татсан. Энэнээс хойш бол энэ зоос бол үндсэндээ 38 онд татагдахдаа баланст хөрөнгөөр бүртгэгдсэн. Тэгээд эдгээр зоос нь Монголбанк руу бол өвлөгдөж ирсэн юм. гэдэг ийм байр суурийг илэрхийлдэг.

Хяналтын зөвлөл бол бид нар болон бидний өмнөх хяналтын зөвлөл энэ асуудлыг судалж үзээд тэгээд Монголбанкны удирдлагад бол энэ 25 оны мөнгөн зоосыг бол хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэн дахин үнэлсэн үйл ажиллагааг бол энэ хөндлөнгийн аудитын шаардлагын дагуу холбогдох хууль тогтоомж болон нягтлан, санхүүгийн тайлагналын олон улсын стандартын шаардлагад нийцүүлж арга хэмжээ авахыг бол зөвлөсөн. 2025 оны 4 сарын 7-ныхоо тогтоолоор зөвлөсөн. Бидний өмнөх Хяналтын зөвлөл бол энэ асуудал дээр мөн удаа дараа энэ зөвлөмжийг өгсөн байдаг.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар сая Ерөнхийлөгч бол товчхон дурдлаа. Ашиг, алдагдал бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан гээд ийм 5 тайлангаас бол бүрдэж байгаа.

Бидний санал, зөвлөмж бол 2 хуваагдсан байгаа. Нэг нь бол Улсын Их Хурал болон Эдийн засгийн байнгын хороонд гээд 3 санал, зөвлөмж. Монголбанкны удирдлагад гээд 3 санал, зөвлөмж байна.

Улсын Их Хурал Эдийн засгийн байнгын хороонд Төв банк Монголбанкны тухай хуулийн 38¹-ийн заалтын хэрэгжилт буюу нийт өр төлбөр нийт хөрөнгийн зөрүү болох 4.8 их наяд төгрөгийг Засгийн газрын үнэт цаас гаргах замаар нөхөх асуудлыг шийдвэрлэх нөхцөл байдал үүссэн байгаад анхаарна уу. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, бол Төв банк нь хуримтлагдсан алдагдалтай үед тухайн жил ашигтай ажиллах буюу цэвэр орлого эерэг гарвал 38.3 заалт үргэлжлэх эсэх нь тодорхой бус байгаад анхаарч шаардлагатай холбогдох заалтад хуулийн өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.

Гуравдугаарт, нь бол Улсын Их Хурлын 2027 оны 23 дугаар тогтоол, 2020 оны Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс 1 удаа төлөх тухай зэрэг хууль, тогтоол шийдвэрээр Монголбанканд санхүүгийн үр дагавар бүхий үүрэг чиглэл өгөх нь Монголбанкны санхүүгийн байдал болон бие даасан хараат бус байдалд сөрөг нөлөөлж буйд анхаарах хэрэгтэй байна гэсэн ийм 3 зөвлөмжийг санал болгож байна.

Монголбанкны удирдлагад бол Засгийн газарт олгосон зээл нь Төв банканд санхүүгийн эрсдэл учруулж буй тул цаашид энэ төрлийн зээлийн нөхцөл, гэрээ болон эргэн төлөлт дээр анхаарах, улмаар төсвийн шинжтэй үйл ажиллагааг санхүүжүүлэхээс татгалзах гэсэн ийм санал өгч байна. Он дараалан хязгаарлалттай дүгнэлттэй, тэгээд их хэмжээний хуримтлагдсан алдагдалтай явах нь үйл ажиллагаа болон санхүү, нэр хүндийн эрсдэл үүсгэж байгаад анхаарах. Тэгээд мөнгөний бодлогын нөлөөллийг нэмэгдүүлж, хүүгийн зардлыг бууруулах чиглэлд ажиллах гэсэн ийм 3 зөвлөмж өгсөн байна.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. Бядрангийн Лхагвасүрэн Монголбанкны Ерөнхийлөгч, Баярсайханы Баярдаваа Мөнгөний бодлогын газрын захирал, Атарбаатарын Энхжин Санхүүгийн зах зээлийн газрын захирал, Дамдинжавын Даваасүх Судалгаа, статистикийн газрын захирал, Цэдэвсүрэнгийн Нарандалай Хяналт шалгалтын газрын захирал, Нинжбатын Ууганбаатар Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, Раднаасэдийн Даваадорж Мөнгөний бодлогын хорооны гишүүн, Намсрайн Батнасан Мөнгөний бодлогын хорооны гишүүн.

Монголбанкны 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмж болон Улсын Их Хурлын Тамгын газраас Монголбанкны 2024 оны санхүүгийн тайланд хийсэн дүн шинжилгээг та бүхэнд тараасан байгаа.

Санхүүгийн тайлан болон Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Энэ асуулт үгийг салгачих уу? Тэгээд салгая. Эхлээд асуулт асуух хүмүүс, гишүүд нэрсээ өгье.

Энхтүвшин Соронзонболд гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Ундраа асуулт асууна. Айн? Алдаржавхлан, Бадамсүрэн гишүүнийг нэмье.

Төхөөрөмж ажиллахгүй байна. Алдаржавхлан, Бадамсүрэн. Ингэхээр ирцээрээ дээшээ доошоо болчхож байна уу? Ундраа гишүүн.

А.Ундраа: Энэ тайланг сонслоо. Тэгээд бас өчигдөр хүлээж аваад бас заримтай нь танилцсан. “Пи Даблью Си”/PwC/-ээс өгсөн үнэлгээгээр бас зарим учир дутагдалтай талуудыг онцолж гаргаж хэлсэн байна. Тэгэхээр бас Засгийн газрын зүгээс зарим явуулж байгаа бодлого Монголбанкны хараат бус байдалд халдах, эсвэл хараат бус байдлыг тодорхой хэмжээнд алдагдуулах тийм улс төрийн нөхцөл байдал бас үүсгэж байсан гэж би ойлгодог. Тэгэхээр энийг цаашид анхаарах. Энэ хараат бус байдлыг илүү бэхжүүлэх Засгийн газраас зарим популист маягийн амлалтуудыг биелүүлэхийн тулд мөнгөний бодлогод сөрөг үр дагавартай шийдвэр гаргуулахгүй байх талаас нь ямар ямар арга хэмжээ авъя гэж төлөвлөсөн байна? Үйл ажиллагааны төлөвлөгөөг нь хавсралтаар бичсэн байна. Тэгээд маш олон зүйл байгаа учраас нэг бүрчлэн харж чадсангүй. Гэхдээ тоймлоод тэр хараат бус байдал бэхжүүлэх чиглэлээр юу хийж байгаа вэ, ямар ажил төлөвлөж байгаа вэ гэдгээ хэлбэл сайн байна.

Хоёрдугаар асуулт 2020 онд байх, 19 онд Лхагвасүрэн Ерөнхийлөгч бас санаж байгаа байх. Бид санаачлаад Эрдэнэсийн сангийн тухай хууль боловсруулж батлуулж байсан Улсын Их Хурлаар. Тэгээд би өргөн бариад боловсруулаад хэлэлцэх шатдаа явж байх үед дараагийн парламентын бүрэн эрх хэрэгжиж эхлээд энэ Бямбацогт гишүүн ахлаад тэгээд Эрдэнэсийн сангийн тухай хууль батлагдаж байсан. Тэгэхээр Эрдэнэсийн сангийн нөөцөд байгаа энэ зоосны үнэлгээг сайжруулах талаар хийсэн ажлыг бас их зөв зүйтэй ажил гэж харж байна. Тэгэхдээ ер нь Эрдэнэсийн сангийн тухай хуулийн хэрэгжилт ер нь ерөнхийдөө ямар байгаа вэ? Энэ нөөцөд байгаа зоосны үнэлгээг орчин цагийн, өнөө цагийн үнэлгээтэй нийцүүлэх, тэгээд даатгал, давхар даатгалын системд хамруулах, бүрэн бүтэн байдлыг хангах, Эрдэнэсийн сангийн бусад хосгүй үнэт өв, үнэлгээ нь ямархуу байдалтай байна, бүртгэл нь хэр зэрэг сайн байна гэдгийг тодруулж хэлбэл сайн байна.

Эрдэнэсийн сантай холбоотой бас асуудал бол алтны нөөцийг бүртгэх асуудал бас Эрдэнэсийн сан дээр явж байгаа хэвээрээ гэж ойлгож байгаа. Тухайн хуулиар тэгж батлагдаж байсан. Тэгэхээр алтыг нөөц мэдээж нэмэгдэх нь улсын сан хөмрөг, мөнгөний бодлого аль ч талаараа бай хэрэгтэй.

Гэхдээ хаанаас ямар алт ирж байгаа вэ гэдэг нь бас өөрөө их чухал асуудал. Тэгэхээр тэрний дам нөлөө буюу байгаль орчны нөлөө алтны эх үүсвэрийн асуудал дээр ер нь ямар нэгэн трэйсинг хийх тийм ал арга алхмууд авч байна уу авах төлөвлөгөө байна уу, энэ талаар хэлж өгөөч? Баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн 3 номер Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Ундраа гишүүний асуултад хариулъя. Ерөнхийдөө Монголбанкны энэ хуримтлагдсан алдагдал бас яг тэр 2017 оноос эхлээд ингээд том дүнгээр бас гарч ирсэн. Энэ нь өмнө нь байсан тэр төсвийн шинжтэй арга хэмжээнээс үүссэн гэдгээрээ энэ аудитын тайланд дурдагдсан байгаа юм. Энэ алдагдлыг цааш нь нэмэгдүүлэхгүй байх талаар Монголбанк бас арга хэмжээ аваад явж байгаа. Өнөөдөр байгаа энэ сөрөг болчихсон байгаа 4.4, тэр 4 их наяд гаруй төгрөгийн алдагдлын үүсэхэд гол шалтгаан нь ер нь бодлогын хүүгийн зардал явж байгаа. Төв банкны үнэт цаасны хүүгийн зардал өнөөдөр бол эдийн

засаг дээр байгаа илүүдсэн хэсгийг Монголбанк өөр дээрээ татаж авч шингээх маягаар энэ эх үүсвэрийг өөр дээрээ цуглуулдаг.

Тэгээд бодлогын хүү буюу өнөөдөр бодлогын хүү 12 хувьтай байгаа учраас энэ хүүгээр хүү төлөөд энэ нь өөрөө Монголбанкны зардал дээр хамгийн нэлээн бараг нийт алдагдлын бараг 30 гаруй хувийг энэ хэсэг эзлээд явж байгаа юм. 66 хувийг, 60 гаруй хувийг нь. Тэгэхлээр бодлогын хүүгийн зардал маягаар ингээд явж байгаа. Энэ дээрээ Монголбанкны зүгээс аль болохоор ямар зүйл дээр илүү их ажиллаж байгаа вэ гэхлээр Засгийн газартай ялангуяа буюу Сангийн яамтай илүү их ярьж байгаа. Ялангуяа Сангийн яам болон Засгийн газрын үнэт цаас гарч явах юм бол төв банкны үнэт цаас заавал энэ дээр байх шаардлагагүй болох юм. Тэгэхлээр Засгийн газрын дотоодын үнэт цаасыг гаргах тал дээр илүү хамтарч ажиллая гэдгээрээ ингээд яасан.

Тэгээд энэ оны сая энэ 5 дугаар сараас эхлээд Засгийн газар анх сүүлийн 6, 7 жил, бараг 8 жил гаргаагүй байсан завсарлаж байсан юунаасаа эхний үнэт цаасаа ингээд гаргаад эхэлж явж байгаа. Тэгэхлээр энэ дээр ингээд алдагдал цаашдаа буураад явах байх гэж харж байгаа.

Нөгөө нэг алдагдлын томоохон шалтгаан тэр Хятадын Ардын банктай хийсэн своп хэлцлийн хүүгийн зардал байгаа. Тэгэхлээр своп хэлцлийнхээ хүүгийн зардлыг бууруулах талаар түрүүчийн арга хэмжээнүүдийг авсан. 12 их наяд тэрбум юунаар хэмжигдэж байсан өрийг 50 хувиар бууруулсан байгаа. Ингээд 6 их наяд. Тэгэхлээр үүгээрээ ингээд хүүгийн зардал маань ингээд буураад явж байгаа. Тэгэхлээр ингээд энэ гол гол бодлогын шинжтэй зардлууд байгаа учраас энэ дээрээ арга хэмжээгээ авч яваад ер нь алдагдлаа бууруулах бүр тэглэх тал руу нь л зориод ингээд ажиллаад явж байгаа гэж.

Эрдэнэсийн сангийн хууль батлагдсан. Эрдэнэсийн сангийн хууль батлагдаад яг одоо хэрэгжээд явж байгаа. Яг өнөөдөр Эрдэнэсийн сантай холбоотой хуулийг яг л хуулийнх нь дагуу ажиллаж байгаа учраас энэ дээр ямар нэг зөрчил, дутагдлын зүйл байхгүй. Манай яах вэ санхүүгийн тайлан дээр байгаа тэр гаднын аудитын байгууллагын зөрүүтэй дүгнэлт буюу тэр зоосон дээр байгаа дүгнэлт байгаа юм. 2017 онд Монголбанк өөрийн тэр 1925 онд гаргасан мөнгөн зоосоо олон улсын үнэлгээний компаниар үнэлүүлсэн. Тэгээд үнэлүү.../минут дуусав./

Р.Сэддорж: Хариулт гүйцээж хариулъя. 3 номер.

Б.Лхагвасүрэн: 2017 онд Бельгийн, Францын үнэлгээний компаниар үнэлүүлээд үнэ тогтоолгосон юм. Тэгээд тэрүүгээрээ санхүүгийн тайландаа тусгачихсан явж байсан. Өнөөдөр энэ “Пи Даблью Си”/PwC/ компани яагаад энийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа гэхлээр энэ төв банкны өөрийнх нь гаргасан зоос учраас өөрийнх нь номинал үнэ буюу тухайн үеийн 1 төгрөг гэдэг үнээрээ л үнэлэгдэх байх ёстой. Тэрнээс биш тэр өнөөдрийн тэр мөнгөөр, мөнгөн зоос 18гр-ын мөнгөн зоос буюу 18гр мөнгөөрөө үнэлэгдэх нь буруу байна л гэдгээрээ л зарчмын ийм зөрүүтэй юман дээрээ л санал зөрөлдөөд байгаа юм. Тэгээд нэлээн ч удаан хугацаанд явж байгаа. Тэгээд Монголбанк өөрөө энийг манай нэгэнт Эрдэнэсийн сангийн тухай хуулиар Эрдэнэсийн сандаа бүртгэчихсэн учраас энэ үнэ дээрээ бид дахин үнэлгээ хийх буюу буцаах зүйл гаргахгүй гэдгээрээ л ийм байр суурь илэрхийлээд зарчмын зөрүүтэй болчихоод байгаа юм. Алтны нөөцийн

хувьд Монгол Улс өөрөө олборлодог улс учраас дотоодын олборлосон алтаараа хийж байгаа. Тэгээд Швейцар.../минут дуусав./

Р.Сэддорж: Ундраа гишүүн тодруулж асууя.

А.Ундраа: Ер нь энэ алтны нөөц нэмэгдүүлэх асуудал алтны эх үүсвэрийг баталгаажуулах чинь өөрөө бас маш их ийм комплекс байгаад байгаа тийм. Тэгэхээр татвартай юм уу, АМНАТ-тай уялдаатайгаар хэт их өндөр бол яг тушааж байгаа хэмжээндээ шууд нөлөөлөх зэргээр яг мэдэгддэг. Тэгэхээр бидний ярьдаг нөгөө нинжа буюу гараар олборлож байгаа байгаль орчин нь маш их халгаатай, нөхөн сэргээлт хийдэггүй тэдгээр уурхайгаас ирж байгаа юм уу эсвэл хар, далд эдийн засаг гээд хэлчихье л дээ. Тэрэнтэй уялдаатай байгаа эсэхийг цэгцлэхэд энэ нөөцийг бүртгэлжүүлэх асуудал маш чухал байгаад байгаа. Тэгэхээр түрүүний асуулт дээр ахиад тодруулмаар байна. Цэвэршүүлэх талаар илүү яриагүй би, эх үүсвэрийг баталгаажуулах чиглэлээр яриад байгаа юм.

Р.Сэддорж: 3 номер хариулъя.

Б.Лхагвасүрэн: Монголбанк алт худалдаж авахдаа мэдээж гарал үүсэл хэнд, яаж тушааж байгаа гэдгийг бүгдийг нь шалгаж байгаа.

Тэгэхлээр Монгол Улс нөгөө үндсэн уурхайн, үндсэн ордын уурхайнаас дийлэнх нь цуглаж байгаа учраас тэр дээр ойлгомжтой байгаа. Бусад жижиг алт тушаагчдын хувьд Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан тэр этгээдээс авч байгаа юм. Тэгэхлээр ямар гарал үүсэл байхгүй зүйлүүдийг Монголбанк худалдаж авахгүй байгаа.

Нөгөө талаар манай алтыг цэвэршүүлдэг Швейцарын тэр “Argor” компани 2 жил тутам Монголд ирж уул уурхайн компаниудаар явж байгаад тушаадаг тэгээд нөгөө байгаль экологид ээлтэй байх, бас бусад нөгөө бусдын хөдөлмөрийг мөлжиж байгаа хэсэг дээр нь дүгнэлт гаргаад явж байгаа учраас Монголбанкны тушааж байгаа алт буюу манай алтны гарал, үүсэл бол олон улсад яг нийгмийн хариуцлага талаасаа цэвэр алт гэдгээр бас хүлээн зөвшөөрөгдөж байгаа.

Р.Сэддорж: Дашсүрэнгийн Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Засгийн газар, Монголбанк маань бас зарим талаараа Засгийн газартай их хавсарч ажиллаад байгаа. Энэтэй холбоотой 2, 3 асуулт байгаа. Энэ 38-ын штрихтэй холбоотой заалтыг Сангийн сайдаас бас асуусан 4.8 их наяд, 9 их наядыг Засгийн газар өрийн бичиг гаргаж санхүүжүүлэх хуулийн ийм боломж байгаа. Гэхдээ энийг Сангийн яам бол яг өөрсдийн санаачилгаар бол хийх шинжгүй юм байна лээ. Тэгэхээр Монголбанк хийсэн бас харахад бас яг энийг хийх сонирхол байхгүй байгаа юм уу даа гэж харсан. Өнгөрсөн хугацаанд бас тодорхой ахиц дэвшил гарахгүй байгаа учраас тэгэхээр Их Хурлаас ч юм уу ялангуяа энэ иргэдийн төлөөлөл болж байгаа байгууллагын хувьд бас энэ дээр жоохон шахъя гэж бодож байна. Тэгэхээр Лхагвасүрэн Ерөнхийлөгчөөс яг энэ чиглэлээр яг Монголбанкны зүгээс санаачилга болон Сангийн яамнаас ямар санаачилга гараад ямар уулзалтууд ярианууд болсон бэ гэдэг талаар мэдээлэл өгөөч.

Хоёрдугаарт, нь энэ тэтгэврийн зээлийг Эрдэнэс бондтой холбоотой тэтгэврийн зээлийг 1 удаа тэглэхтэй холбоотой энэ Монголбанк энэ найдваргүй эрсдэлтэй шатлал 3 руу оруулчихсан байна л даа. Тэгэхээр дүн нь ч гэсэн 850

орчим тэрбум төгрөгийн ийм дүн байна. Тэгээд энийг яая гэсэн бодолтой байгаа, яг энэ эрсдэлд бичилт хийх юм уу? Энэ Монголбанк энийг зардлыг нь үрээд явах юм уу?

Гуравдугаарт, нь энэ бас яг Засгийн газартай холбоотой энэ Эрдэнэт үйлдвэр Монростой холбоотой, авлагатай гэрээтэй холбоотой 650 орчим бас тэрбум төгрөгийн Худалдаа хөгжилтэй холбоотой энэ асуудлыг уул нь энэ чинь сүүлд 25 онд Сангийн яамнаас, сайдаас өгсөн бичиг дээр 10 жилийн хугацаатай гэж бичсэн юм шиг байгаа юм. Зүгээр энэ дээр бичсэнээр болохоор анх эхэлж энэ үүссэн хугацаа нь өмнө байсан мөртөө яагаад ийм урт хугацаагаар эхний гэрээн дээрээ хугацаа заагаагүй байсан юм уу тэгээд сүүлийн бичиг дээр яагаад ийм 10 жилээр тавьсан юм бэ гэдэг 1 асуулт байна.

Өөр нэг болохоор энэ, гэхдээ яг энэ хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоогүй ч гэсэн Лхагвасүрэн Ерөнхийлөгчийг байгаа дээр нь би юунаас асууж байсан энэ аж ахуйн нэгжүүдийн зээл авахад бас энэ барьцаатай холбоотой асуудал чухал байдаг. Тэгэхээр энэ хийсэн гэрээгээ, том компаниудтай ч юм уу хийсэн гэрээгээ барьцаалаад зээл авах боломжийг бас яг Монголбанкнаас энэ хамтарсан Сангийн сайд Монголбанкны хамтарсан 2024 оны 4 сарын 6-ны А61, А65 дугаар тушаалын хавсралт гээд зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээний журам гээд энэ дээр энэ 1.10 дээр нь банк гэрээний шаардах эрхийг барьцаалан зээл олгож болно гэсэн ийм заалт байгаа юм. Тэгээд энэ заалтын хэрэгжилт бас ямаршуу байгаа юм? Аж ахуйн нэгжүүд бас яг энийг сайн мэдэхгүй хэрэглэж чадахгүй байна л даа. Банкнудаас бас энэ заалтыг ашиглах тал дээр ямаршуу хүндрэлүүд байгаа юм гэдэг ийм асуултууд байна. Баярлалаа.

Р.Сэддорж: 3 номер.

Б.Лхагвасүрэн: Түрүүн би бас Ундраа гишүүний асуултад хариулахдаа бас Монголбанкнаас хийсэн ажлуудыг бас дурдсан байгаа юм. Тэгээд өнөөдөр манай санхүүгийн тайлангаар сая 2024 онд Монголбанк 300 тэрбум төгрөгийн орлого олсон. Тэрүүгээрээ өнөөдөр Монголбанкны хасах хөрөнгө гэдэг 5.1 байсныг 4.8 болгоод ингээд бууруулчихсан байгаа. Тэгэхлээр ингээд бууруулаад явж байгаа нь Монголбанк аль болохоор энэ алдагдлыг өөрөө бууруулъя гэсэн л ийм л эхний ийм ажлыг хийгээд явж байгаа юм. Сангийн сайдтай уулзсан. Сангийн сайд болохлоор энэ 4.8 их наяд гэдэг өөрөө улсын төсөв дээр их том дарамт болохоор тоо учраас шууд нэг дор шийтгэх арга ер нь байхгүй. Тэр утгаараа ер нь яг энэ асуудлыг жоохон хүлээнзэе, харзнаж байж ярья л гэдгээр л ийм байр суурь л илэрхийлсэн. Тэгээд бид аль болохоор энийг өөрсдөө л барагдуулъя гэсэн байр суурьтай л байгаа ажиллаж байгаа.

Хоёр дахь тэр 849 тэрбум төгрөгийн Эрдэнэс бонд байгаа. Энэ нөгөө тэтгэврийн зээлийг тэглэхэд “Эрдэнэс Монгол” компанийн гаргасан бонд. Хугацаа нь дууссан учраас бид хэд энэ дээр тодорхой хэмжээний эрсдэлийн сан гэдгийг байгуулаад явж байгаа юм. Тэрнээс биш энэ угаасаа ерөөсөө төлөгдөхгүй буюу Монголбанк хариуцна гэдгээр биш олон улсын нягтлан бодох бүртгэлийн нөгөө зааврынхаа дагуу энэ зээл чинь хугацаа нь дуусчихлаа энэ өрийг чинь, өрийг нь хугацаа нь дууссан учраас тодорхой хэмжээгээр эрсдэлийн сан байгуул гэдэг нөгөө нягтлан бодох бүртгэлийнхээ аргачлалаараа энийг ингээд байгуулаад явж байгаа. Энэ дээр сүүлд Засгийн газар бас тодорхой хэмжээн дээр нь баталгаа гаргана гэдгээр бас Засгийн газрын тогтоол гарсан байна лээ. Тэгээд тэр утгаараа энэ мөнгө ер нь төлөгдөнө л гэж Төв банкны зүгээс харж байгаа юм.

657 тэрбум төгрөг бол “Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувийн нөгөө Монголд оруулж ирэх гарсан төлбөр тооцоотой асуудал байгаа. Энэ дээр Улсын Их Хурлаас гарсан тогтоол нь Эрдэнэтийн тэр 49 хувийг төрд шилжүүлэхдээ төлбөр, тооцоог нь цэвэршүүлэх харилцан өр, авлагыг цэвэршүүлэх замаар хийе гэдгээр тогтоол гарсан. Тэр хүрээнд Монголбанкнаас, Худалдаа хөгжлийн банкнаас авах авлага байсан. Энэ авлага нь өөрөө энэ 675 тэрбумаар нэлээн хэд хэдэн хөтөлбөр яана. шатахууны компаниудад олгосон зээл ч гэдэг юм уу, алтны компаниудад урьдчилгаа маягаар олгочихсон хөтөлбөрийн зээлүүд байсан. Энэ хөтөлбөрийн зээлийн авлагыг энэтэй ингээд харилцан хайчлах замаар ингээд авсан. Одоо тэгээд Монголбанкн дээр 657 тэрбум төгрөгийн энэ авлага бол нэг бол Засгийн газраас, нэг бол Эрдэнэт үйлдвэрээс буцааж төлөгдөнө гэсэн маягаар санхүүгийн тайлан дээр ингээд тусгагдчихсан явж байгаа.

Тийм яах вэ энэ өөрөө ингээд нэгэнт л Монгол Улсад шилжиж орж ирсэн гэдэг утгаараа яг энийг нэг дор төлөх юм уу, төсөв дотроо ингээд бага багаар суулгаад явах юм уу, Эрдэнэт үйлдвэр төл.../минут дуусав./

Р.Сэддорж: Гүйцээж хариулья 3 номер.

Б.Лхагвасүрэн: Таны хэлсэн журам ингээд өөрчлөгдөөд гарчихсан байгаа. Өнөөдрийг хүртэл Монголбанкн дээр энэ талаар ямар санал санаа оноо шүүмжлэл гэдэг юм уу, гомдол, санал ирээгүй учраас энэ журам бол хэрэгжээд явж байгаа гэж Төв банкны зүгээс харж байгаа. Тэгээд арилжааны банкнуудаас асуухад ер нь энэ гэрээ, хэлцэл ялангуяа Оюу толгойтой бэлтгэн нийлүүлж байгаа компаниуд энэ асуудалгүйгээр энэ гэрээгээ барьцаалж байгаа гэж хариулсан.

Р.Сэддорж: Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Тийм. Тэгэхээр тодорхой хэмжээний Засгийн газрын ачааг Монголбанк маань бас яг нэг карма гэж хэлээд яг иймэрхүү үүргүүд л бас гүйцэтгээд л яваад байна л даа. Уул нь Монголбанкны зорилго чинь бас арай жоохон өөр төгрөгийн тогтвортой байдалтай холбоотой. Тэгэнгүүт Засгийн газар дээр жишээлбэл тэнд зарим шийдэж чадахгүй хязгаарт орсон асуудлуудаа яг ингээд Монголбанкийг нэг карма болгоод ашиглаад байгаа нь бас ингээд эдийн засгийн бодит үзүүлэлтүүдийг яг энэ менеж хийхэд бид нар ачааллаасаа давсан, тэлсэн гээд ийм юмнууд хийж байгаа дүр зураг харагдаад. Тэгэхээр яг саяын асуудалтай холбоотой ер нь яг энэ Засгийн газрын тодорхой хэмжээнд жишээлбэл та хэд дүр зураг харж бай, танай дээр байж бай гэсэн өөр нийт дүнгээрээ ямаршуу дүн тооцоо байдаг вэ? Тийм багцаа байдаг уу?

Р.Сэддорж: Лхагвасүрэн ерөнхийлөгч 3 номер.

Б.Лхагвасүрэн: Ер нь ингээд энэ 3.6 том дүнгээрээ. Тэрний 849 нь энэ Эрдэнэс бонд тэтгэврийн зээл тэглэсэн. 657 саяын Эрдэнэт үйлдвэрийн 49 хувийг худалдаж авахад хэсэг. Тэгээд алтны урьдчилгаа, Хүнсний хувьсгал гэх мэтчилэнгээр ингээд зээлүүд байгаа. Тэгэхдээ тэр дотор тийм том дүн, таны саяын хэлж байгаа Засгийн газар дээр байгаа ачааг үүрэлцэж байгаа ийм зүйл энэнээс өөр байхгүй. Тэгээд энэ 2 зээл ерөнхийдөө хоёулаа Улсын Их Хурлаас нэг нь хууль, нэг нь тогтоол болж гарчихсан учраас Монголбанк тэрийг үндэслэж энэ гүйлгээнүүдийг хийчихсэн байгаа.

Р.Сэддорж: Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууна.

М.Бадамсүрэн: 2 үндсэн асуулт байна. Ер нь энэ тайланг илүү тодорхой ялангуяа энэ макро түвшний асуудал дээр түлхүү тайлагнавал сайн байна гэдгийг хэлье. Хяналтын зөвлөлийн хувьд ч гэсэн энэ зүйл дээр илүү анхаараач ээ.

2 асуулт байгаа. Нэгдүгээрт инфляцыг бууруулах чиглэлээр, инфляцыг хязгаарлах чиглэлээр ер нь Монголбанкны, Төв банкны яг хамгийн гол үүрэг юу вэ? Бодлогын хүүг өсгөхөөс гадна өөр ямар эрх, үүрэг байна? Өөрөөр хэлбэл хууль, эрх зүйн орчныг шинэчлэх сайжруулах. Тухайлбал энэ асуудлаар зохицуулалт хийсэн эрх зүйн өөр орчныг бүрдүүлэх шаардлага байгаа юу? Мөн Засгийн газрын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд Их Хурлын байгууллага болох төв банк яаж энэ дээр харилцан тэнцвэртэй, харилцан хяналттай үйл ажиллагаа явуулдаг вэ? Засгийн газрын авч хэрэгжүүлж байгаа бодлого дээр ямар зөвлөмж өгдөг вэ? Өөрөөр хэлбэл олон нийтэд ингээд Төв банк ингээд Засгийн газрын заавраар ажиллаад байна. Бие даасан бодлого төдийлөн сайн явуулж чадахгүй байна. Бодлогын хүүг дээш нь доош нь болгохоос өөр зүйл хийхгүй байна гээд. Тэгэхээр ард иргэд шүүмжлээд байгаа шүү дээ төрийн төсвийн зарлага өндөр байна. Энийг яаж бууруулах юм бэ? Урсгал зардлыг ДНБ-ий 24 хувиас ихгүй байна гээд сая Хөгжлийн төлөвлөгөө дээр баталчихлаа. Энэ тал дээр нь ер нь яг яаж явдаг юм бэ? Яагаад би энийг асууж байна гэхээр ингээд ийм бие бие рүүгээ Засгийн газар, Монголбанк 2 бие бие рүүгээ оруулаад тэгээд ингээд ийм эзэн биегүй юм шиг л харагдаад байна л даа.

Тийм учраас энийг яг тийм тодорхой болгох хэрэгтэй. Энэ дээр миний хувьд энэ илүү үр дүнтэй ажиллаасай гэсэндээ л ингэж байгаа юм. Зарим оронд инфляцыг бууруулах тухай түр баталсан хууль ч байна. КОВИД-ын үед баталсан ийм зохицуулалтууд байна. Эндээс ер нь яг манай Монголбанк ямар зүйлийг судалсан байдаг вэ? Өөрөөр хэлбэл энэ Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо энэ дээр хууль, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр юунд анхаарах вэ гээд. Нэг.

Хоёрдугаарт нь энэ Үндэсний баялгийн сантай холбоотой Ирээдүйн өв сангийн хөрөнгө бодлогын хүүтэй тэнцүү хэмжээгээр арвижуулна. 30 он хүртэл энэ хөдөлгөөнгүй арвижуулна гээд байгаа. Энэ ер нь ямар явцтай яваа вэ? Одоо яг хэдэн төгрөг Ирээдүйн өв санд байна? Хуримтлалын сан болон Хөгжлийн санд яг хэдэн төгрөг байна? Энэ дээр Монголбанканд яг аль сан нь аль хуримталж байгаа хөрөнгө нь хамааралтай байдаг вэ? Энийг ер нь яаж зохицуулж байна вэ? Тэгээд би энэ дээр Байнгын хорооны даргад хандаж ажлын хэсэг хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулах саналтай байгаа. Баялгийн сан.

Р.Сэддорж: Хариулт тодорхой хариулаарай. 3 номер Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Тийм инфляц хэрэглээний сагсанд байгаа 429 бараа, бүтээгдэхүүний тэр хаашаа хөдөлж байгаа хөдөлгөөнийг л илэрхийлж байгаа ийм үзүүлэлт байгаа л даа. Тэгэхлээр инфляц өөрөө ерөнхийдөө 2 шалтгаанаар өсөж, буурах магадлалтай. Нэг нь эрэлтийн шинжтэй, нэг нь нийлүүлэлтийн шинжтэй гэж байгаа. Тэгэхлээр эрэлт гэдэг маань өөрөө эдийн засаг идэвхжээд халаад ирэхлээрээ эдийн засагт байгаа, мөн мөнгөний хэмжээ нэмэгдээд ирэхлээр эрэлтийн шинжтэйгээр ингээд инфляц хөөрөгддөг байгаа.

Нөгөөдөх нь зардлын шинжтэй буюу зардал өсөөд ингээд нийлүүлэлтийн шинжтэйгээр үнэ ингээд хөөрөгдөж яваад инфляц өсөх ийм л 2 л зүйл байгаа л даа.

Төв банкны хувьд зөвхөн эрэлт дээр нь ажилладаг ийм институц. Тэгэхлээр эрэлт гэдэг маань өөрөө хэт эдийн засаг халаад, халсан эдийн засгаасаа үнэ хөөрөгдөж байна уу гэдэг дээр нь л арга хэмжээгээ авч байгаа юм. Тэгэхлээр аль ч улсын төв банк яг л энэ бодлогын хүүгээрээ л ажиллаж байгаа. Өнөөдөр АНУ-ын Холбооны нөөцийн банк бас л бодлогын хүүгээ өндөр түвшинд барьж байгаа нь ирээдүйд бий болж байгаа инфляцыг л урьдчилж л багасгах талаас арга хэмжээ авна. Тэрэнтэй адилхан өнөөдөр төв банк бодлогын хүү 12 болгоод тавьж байгаа нь цаашид инфляц нэмэгдэх энэ тодорхой бус байдал байгаа учраас энэ бодлогын хүүг хатуу хэмжээнд барьж л ингээд явж байгаа.

Тэгэхлээр нийлүүлэлтийн шинжтэй буюу ямар нэг бүтээгдэхүүний зардал, тээврийн зардал, түүхий эдийнх нь зардал өсөөд, гурилын үнэ өсөж, гурилан бүтээгдэхүүний үнэ хөөрөгдөх энэ зүйл дээр Төв банкнаас оролцох ямар ч боломж байхгүй учраас харин эргэлдэж байгаа мөнгийг нь багасгах маягаар эрэлтийг нь бууруулахад зорьж л энэ бодлогын хүүг л ихэсгэж, багасгаж л өнөөдөр ингээд удирдаад явж байгаа ийм зүйл байгаа юм.

Өнгөрсөн онд энэ улсын төсвийг энэ 2025 оны улсын төсвийг батлахад төв банкны зүгээс Сангийн яаманд өөрийн байр суурь буюу албан бичгээ өгч байсан. Ямар ч байсан төсвийг алдагдалгүй байлгаж өгөөч. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, КОВИД-ын өмнө улсын төсөв ДНБ-ий 27 хувиас хэтэрч байгаагүй. Өнөөдөр ДНБ-ий бараг 36, 35 хувьтай тэнцэж байгаа учраас энийг буцааж КОВИД-ын өмнөх түвшин рүү хүргэвэл эдийн засгийн тогтвортой байдал, макро эдийн засаг маань тогтвортой байх юм байна. Инфляц энэ нийлүүлэлтийн шинжтэйгээр хөөрөгдөхгүй байх боломжтой байна л гэдгээрээ бодлогын ийм хэлэлцүүлгээ л тэгж л хамт хийсэн л дээ.

Өнөөдөр Ирээдүйн өв сан дээр 1.2 тэрбум долларын ийм сан хуримтлал үүсчхээд байж байна. Энийг Монголбанк өөрийн нөөцтэйгөө хамт ингээд удирдаад явж байгаа. Тэгээд бидэн гадна байршуулж энийг гээ удирдаж явж байгаа Монголбанк Монгол Улсын валютын нөөцтэй ижилхэн өгөөжийг ингээд өгөөд явж байгаа.

Хуримтлалын сан дээр өнөөдөр 495 тэрбум төгрөг ноднин, өнгөрсөн онд цугласан. Энийг ипотекийн эх үүсвэр маань.../минут дуусав./

Р.Сэддорж: Гүйцээж хариульъя 3 номер.

Б.Лхагвасүрэн: 495 тэрбум төгрөгийг ипотекийн зээлийн эх үүсвэр маягаар ингээд өнгөрсөн онд зарцуулсан. Тэгэхлээр Хуримтлалын сан дээр дахиж энэ дээр мөнгө нэмэгдэж орж ирээгүй байгаа. Ер Үндэсний баялгийн сангийн тухай хуулиар 3 сан байгаа тэрний 2 Ирээдүйн өв сан болон Хуримтлалын сан дээр нь Монголбанк ингэж удирдахад нь хамтарч ажиллаж байгаа. Нөгөө Хөгжлийн сан нь Монголбанктай ямар нэг холбоо, хамаарал байхгүй байгаа.

Р.Сэддорж: Бадамсүрэн гишүүн тодруулж асууя.

Б.Лхагвасүрэн: Тийм төсвийн зардлыг бууруулахаас гадна яг энэ Төв банкны хувьд энэ чинь бүх зүйл хоорондоо уялдаатай байгаа шүү дээ. Энэнээс гадна өөр ямар бодлогын арга хэмжээ авах талаар ер нь зөвлөмж юм уу, санал Засгийн газарт хүргүүлж байгаа вэ л гэж би асуугаад байгаа юм. Юуг бол ойлголоо бодлогын хүүг бол ингээд зохицуулалт хийж байгаа нь байна.

Гэхдээ энэ дээр их санаа зовоод байгаа. Ялангуяа 2026 оны төсөв батлахтай холбоотой энэ зүйл хамгийн их асуудал дагуулна. Тэгээд энэ дээр ийм дорвитой, зоригтой, танайх ийм шахалт үзүүлэх шаардлагатай. Их Хурлын байгууллагын хувьд гэж би ийм саналтай байгаа юм. Тэгээд энийг дэлгэрүүлж бас хариулт өгөөч.

Хоёрт нь энэ баялгийн төрөлжсөн сангуудыг эргэлтэд оруулахтай холбоотой хууль, эрх зүйн орчин яг одоогийнх болж байгаа юу? Жишээлбэл, дотооддоо мөнгөний нийлүүлэлт зээлийн эх үүсвэр бага байдаг. Гэтэл гадаадад иргэд.../минут дуусав./

Р.Сэддорж: 3 номер хариулт.

Б.Лхагвасүрэн: Ер нь Үндэсний Баялгийн сангийн тухай хуулиараа нэгэнт гарц батлагдчихсан байгаа хуулиар 3 сан байна. Ирээдүйн өв сан. Ирээдүйн өв сан бол 2030 он хүртэл энэ зарцуулалт хийгдэхгүй. 2030 оноос хойш зарцуулалт хийгдэхээр байгаа юм. Энэ дээрээ угаасаа Ирээдүйн өв сан ямар эх үүсвэрээс санхүүжигдэх вэ гэхлээр АМНАТ-ын тодорхой хэсэг буюу 65 хувь нь тийшээ очиж байгаа учраас эх үүсвэр тодорхой. Тэгэхлээр 2030 он хүртэл гар хүрэхгүй учраас энийг арвижуулаад, хуримтлалыг нь нэмээд удирдаад явах л ийм л зохицуулалт байгаа.

Хуримтлалын санг Монголдоо ашиглаж болно. Энэ нь эхний ээлжид ипотекийн зээлийн эх үүсвэр болгож ашиглая гэдгээр л ингээд бүртгэгдээд явж байгаа. Хуримтлалын санг өөрөө энэ ер нь хуулиараа хувь хүн болгоны нэр дээр бүртгэгдээд тэнцүү хуваагдаж явах ёстой. Тодорхой зүйлд зарцуулагдахаар бас хуульчлагдсан байгаа. Энэ эрүүл мэнд, боловсрол, орон сууцад нь энийг зарцуу.../минут дуусав./

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзвэл Бадамсүрэн гишүүн.

Б.Лхагвасүрэн: Лхагвасүрэн Ерөнхийлөгч би ингэж асуугаад байгаа юм энэ хуулийн нөгөө заалтуудыг чинь бүгдийг нь мэдэж байгаа. Эдийн засгийн байнгын хорооны гишүүний хувьд энийг уншаад судалчихсан. Тэгээд би танаас хүсээд байгаа зүйл нь одоо энэ инфляцыг бууруулахад дотоодын зээлийн хүүг бууруулахад дотоодын энэ зээлийн эх үүсвэр дутагдалтай байгаа эх үүсвэрийг одоо шийдвэрлэхэд ямар зүйл хийвэл зөв бэ гэдгийг энэ Монголбанк, төв банк энэ дээр саналаа сайн дэвшүүлж өгөөч л гээд байгаа юм. Эдийн засгийн байнгын хороон дээр цаг гаргаж энэ тайлан, танилцуулга сонсож 25 онд ийм асуудал байсан байна, ийм зүйл дээр бид нар ийм санал, дүгнэлт хийж байна гэдэг ийм тайлан биз дээ? Тэгэхээр ингээд ажил хэрэгчээр Засгийн газар, Их Хурлын Байнгын хороо, Монголбанк энэ нийгэмд хүндрэлтэй ард иргэдэд хүндээр тусаад байгаа энэ асуудлуудыг шийдэхийн төлөө л явъя гээд байгаа байхгүй юу. Тэгэхгүй зүгээр ингээд тайлан сонсоод.../минут дуусав./

Р.Сэддорж: 4 номер хариулъя.

Н.Батнасан: Мөнгөний бодлогын хорооны гишүүн Батнасан. Та бүхний өдрийн амгаланг айлтгая.

Ер нь энэ төсөв мөнгөний бодлогыг уялдуулах инфляцыг сааруулахын тулд энэ асуудал их чухал байгаа. Бас саяхан хууль зүйн шинжлэх ухаан дээр хүн докторын зэрэг хамгаалсан тэр ажлыг ингээд үзэж байхад төсвийн тал дээр нэлээн нарийн зохицуулалтууд хэрэгтэй байгаа. Сая мөнгөний эрэлтийн талын асуудлыг Төв банкнаас эрэлтийн шинжтэй инфляцыг зохицуулах тал дээр аль ажиллаж байгаа.

Гэтэл зардлын талын инфляцыг зохицуулах асуудал төсөвтэй нэлээн холбоотой асуудал байна. Тэгээд Герман, Франц зэрэг орнуудын Үндсэн хууль дотор нь төсвийг ямар хэмжээгээр нэмэгдүүлж болох вэ гэдгийг нь хязгаарлагдчихсан заалттай. Өөрөөр хэлбэл тодорхой хэмжээний интервалаас давсан тохиолдолд парламентаасаа асууж байж төсвөө нэмдэг ийм хуулийн зохицуулалттай юм байна лээ. Тэгээд энийг хийгээд өгчих юм бол манайх.../минут дуусав./

Р.Сэддорж: 4 номер гүйцээж хариулъя.

Н.Батнасан: Хуулийн ийм зохицуулалт хийчих юм бол манайх энэ төсвийн тэлэлтийг тодорхой хэмжээгээр хязгаарлах боломж байгаа гэж ингэж харж байна.

Р.Сэддорж: Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууна.

О.Батнайрамдал: Баярлалаа. Надад тодорхой хэдэн асуулт байна. Нэгдүгээрт дахиад л бид нар нөгөө хүү бууруулах талаараа ярина л даа. Тэгэхээр миний ойлгож байгаагаар Лхагвасүрэн Ерөнхийлөгч бас сүүлийн хэдэн сар гадаадын бас томоохон форумуудад оролцсон гэж ойлгож байгаа. Тэгэхээр ер нь бид нар хүүг, зээлийн хүү бууруулахын тулд улам хамгийн гол нөлөөлж байгаа хүчин зүйл нь буцаад эх үүсвэрийн зардал. Тэгэхээр эх үүсвэрийн зардлыг бид нар дотроосоо биш бууруулах дээр илүү бас гаднаасаа заавал хайх ёстой л доо. Тэгэхээр ер нь гаднын банк Монголд салбараа байгуулахад оруулж ирэхэд тэгэхээр ер нь та гадаадуудтай жишээлбэл хөрөнгө оруулагчтай бусад томоохон үндэстэн дамнасан банкнууд байна. Тэд нартай уулзахад ер нь танд ямар бодол төрж байна? Ер нь боломжтой гэж та дүгнэж байна уу, эсвэл үнэхээр огт боломжгүй гэж үзэж байгаа юм уу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, яах вэ энэ 2024 оны бас жилийн тайлан уншиж байна лээ. Зүгээр би сониуч болоод асууж байгаа юм. Монголбанканд 2024 оны төгсгөлөөр хүний нөөцөөсөө төв аппарат дээрээ 569, хүн орон нутагт 691, ойролцоогоор 1260 хүн ажилладаг юм байна гэж ойлголоо. Зөв үү? Нийлээд 691 юм уу тээ? 691 ойлголоо. Тэгэхээр энэ хүний нөөцийн өсөлт нь зүгээр сүүлийн 5 жилийн хувьд хэр өөрчлөгдөж ирсэн байдаг юм бол? Жишээлбэл жил болгоны өсөлт нь ч юм уу, эсвэл сүүлийн 5 жилд яагаад гэхлээр яах вэ? Монголбанк хүний нөөц талаасаа илүү чадавхтай бас илүү хөдөлгөөн багатай гэж харж байгаа юм л даа. Тэгэхээр энэ дээр хариулт авъя.

Гуравдугаарт, ипотеكتэй холбоотой. Ипотек бол хуримтлалын нэгдсэн сангийн санхүүжилтээр түрүү жил ойролцоогоор 570 тэрбум ороод 24 онд 4.3 их наядын ипотека эргэлдэж байгаа юм байна тээ? Тэгэхээр 25 онд тэгвэл ипотекийн

нэмэлт эх үүсвэр Хуримтлалын нэгдсэн сангаас ороогүй гэж үзэж болох уу тээ? Тэгэхээр одоогийн байгаа эргэн төлөлтөөсөө санхүүжиж байгаа гэж үзэж болох уу? Тэгэхээр ер нь 25 оны хүлээлт Хуримтлалын нэгдсэн сангаас нэмэлт эх үүсвэр орж ирэхгүй хэдэн их наяд хэдэн тэрбумын ипотекийн зээлийн санхүүжилт энэ жилдээ ипотека дээр явна гэсэн үг вэ? Яг үүнтэй холбоотойгоор бас түрээсийн, түрээслээд өмчлөх орон сууцны хөтөлбөр хэрэгжсэн. Энэ дээр иргэдээс маш олон асуудал, асуултууд ирж байгаа юм л даа. Яг энэ түрээсийн байр хайсан иргэд энэ Улаанбаатараар дүүрэн байна. Шууд мөнгөөрөө худалдаж аваад ипотекийн тэр урьдчилгаа 30 хувийг төлж чаддаггүй юм гэхэд түрээслээд өмчлөх тэр хэлбэр лүү хайж байгаа эрэлт маш өндөр байгаа юм.

Тэгэхээр бид нар 150 тэрбум орчим төгрөгөөр энэ түрээслээд өмчлөх орон сууцны хөтөлбөр хэрэгжсэн юм байна. Эргэн төлөлт хэвийн явж байгаа юм байна. Тэгэхээр энэ хөтөлбөрийг цаашдаа бид нар хэрхэн тэлэх боломжтой гэж та дүгнэж харж байгаа вэ? Энийг ер нь бид нар цаашлаад ер нь шууд орон сууц, ипотека гэхээсээ илүүтэйгээр түрээслээд өмчлөх энэ хэлбэр рүү оруулах нь зохимжтой биш.../минут дуусав./

Р.Сэддорж: 1 минут Батнайрамдал гишүүнд.

О.Батнайрамдал: Тэгэхээр нэгэнтээ л ипотека бодлого танай дээр явж байгаа учраас энийг та хариулаад өгөөч.

Дөрөвдүгээрт Батнасан профессор сууж байна асуумаар байна. Ер нь 25 онд макро эдийн засгийн түвшинд геополитик ер нь дэлхий даяар олон үйл явдал болж байна. Тэгэхээр ер нь удахгүй бид нар 26 оныхоо төсвийг удахгүй хэлэлцээд эхэлнэ. Тэгэхээр энэ макро эдийн засгийн түвшинд та Монгол Улсын эдийн засгийг цаашдаа хэр гэж ер нь хөндлөнгөөс мэргэжлийн хүний хувьд дүгнэж байгаа юм? 26 оны төсөв яригдахад бид нар инфляцаа харсан ч гэсэн макро эдийн засгийн шок талаасаа боломжит потенциалтай шок талаасаа харсан ч гэсэн төсөв дээр бид нар ямар зүйлүүд дээр илүү бид нар анхаарах ёстой вэ? Урьд хийсэн алдаагаа давтахгүй илүү эдийн засгийн төлөв хараад ямар зүйлүүд дээр илүү бид нар бодлогын түвшинд анхаарч 26 оныхоо төсөв дээр гишүүддээ илүү анхаарч суух ёстой гэж та бүхэн харж байна? Энийг бас Монголбанкнаас бас давхар асуучихъя. Энэ 4 асуултаа асуугаад нэмэлт.

Р.Сэддорж: 3 номер Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Ер нь Монголбанк хууль, эрх зүйн орчноо нэлээн зөөлрүүлсэн байгаа. Гаднын банкны салбар бие даасан нэгжийг оруулж ирье гэдэг утгаараа. Тэгэхлээр өнөөдөр хүртэл Монголбанканд аль банк санхүүгийн байгууллагаас салбар бие даасан нэгжээ байгуулъя гэж хүсэлт ирээгүй. Гаднын хөрөнгө оруулагчтай уулзахад яах вэ манай зах зээлийг өөрөө жижигхэн гээд байгаа юм 3.5 сая хүнд үйлчлэх.

Тэгэхлээр өнөөдөр энэ зах зээл дээр 12 банк ингээд өрсөлдөөд явж байгаа учраас манай 12 банктай өрсөлдөөд энэ жижиглэнгийн зах дээр ажиллах орон зай нэгдүгээрт байхгүй, тийм зорилго ч байхгүй байна л гэж байгаа юм. Тэр утгаараа ингээд гаднын банкны салбар, гаднын банкны хөрөнгө оруулагч буюу салбар ямар тохиолдолд орж ирэх вэ гэхлээр энд тодорхой томоохон төсөл, хөтөлбөр явбал тэрийг дагаж орж ирнэ л гэж байгаа юм.

Тэгэхлээр ерөнхийдөө уул уурхай байна уу, дэд бүтцийн байна уу, томоохон төсөл хөтөлбөр ажиллавал гаднын банк орж ирж ажиллах юм байна л гэсэн л ийм л төсөөлөлтэй л байж байгаа юм. Солонгосын банкнуудтай, Японы банкнуудтай уулзсан. Японы 2 банкны төлөөлөгчийн газар байсан. Эс Эм Би Си/SMBC/, Эм Юү Эф Жи/MUFG/ гээд. Тэр 2 яг КОВИД-ын үед яг таарсан учраас зардлаа хэмнэх гээд тэр 2 банк гараад явсан байгаа. Өөрснөө удахгүй эргээд Монгол руу орж ирнэ л гэж ярьж байгаа боловч яг өнөөдөр албан ёсоор орж ирээгүй байна л гэж байна лээ.

Хүний нөөцийн хувьд 690 ингээд энэ манай орон нутагт ерөнхийдөө 7-8 ажилтан салбар дээр ажилладаг. Төв дээрээ байгаа ажилтнууд мөнгөний бодлого, валютын ханштай холбоотой, нөөцийн удирдлага, банкны хянан шалгалт гээд яг энэ үндсэн зорилгынхоо функцээр томоохон газрууд нь ажиллаад хууль, эрх зүйн газар ч юм уу, мэдээллийн технологи нь ингээд дэмжлэг маягаар ингээд цуг ажиллаад явж байгаа. Жил болгон тэгж их огцом өсдөггүй. Зүгээр л ганц орон тоо л нэмэгдүүлээд ингээд л өсөөд л явдаг. Тэгэхлээр энэ тоо сүүлийн бараг 5, 6 жил ингээд тогтвортой байж байгаа тоо гэж хэлэхээр.

Ипотекийн зээлийн хувьд өнөөдрийн байдлаар 530 тэрбум төгрөгийн зээл гарчихсан байгаа. Энэ эргэн төлөлтөөсөө л гараад явж байгаа. Өнөөдрийг хүртэл Хуримтлалын сангаас ямар эх үүсвэр орж ирээгүй байгаа учраас энэ нэмэгдэх асуудал нь эрсдэлтэй байгаа гэж хэлж болохоор. Хэрвээ энэ Хуримтлалын сангаас мөнгө орж ирэхгүй бол Монголбанкны эргэн төлөлтөөс 500-аад тэрбум төгрөг буюу энэ мөнгө банкны өөрийнх нь нөгөө 20 хувийн оролцоо гэдгээрээ бас 200-аад тэрбум төгрөг л нэмэгдээд нийт тэгээд жилийн туршид 700-800 тэрбум төгрөг л ипотекийн эх үүсвэр болж гарна.

Тэгэхлээр цаашдаа оны төгсгөл хүртэл хэрвээ Хуримтлалын сангаас мөнгө орж ирэхгүй 200-300 тэрбум төгрөгийн л боломж байна. Өшөө нэмж чадахгүй. Өнгөрсөн онд хуримтлалын сангаас 495 орж ирсэн учраас 1.2 их наядын ипотекийн зээл.../минут дуусав./

Р.Сэддорж: 3 номер гүйцээж хариулъя.

Б.Лхагвасүрэн: Таны ярьж байгаа тэр 150 тэрбум төгрөг нийслэлийн гаргасан бонд байгаа. Одоо түрээслээд өмчлөх ийм орон сууцын бонд. Энэ бондын хэрэгжилт маш сайн явж байгаа. Тэгээд энэ өөрөө КОВИД-ын хуулийн хүрээнд гарсан учраас хууль, эрх зүйн хувьд дахиж яг ингэж бонд босгох нь боломж нь хууль, эрх зүйн талаасаа хязгаарлагдчихаад байгаа юм.

Тэгэхдээ энэ өөрөө бас нэлээн ажиллах боломжтой бонд гэж төв банкны зүгээс харж байгаа. Ер нь Засгийн газраас хэрвээ бонд эх үүсвэр маягаар гаргаж ирвэл энэ угаасаа туршигдчихсан ийм сайн схем гэж төв банкны зүгээс харж байгаа. Ер нь төсөв өөрөө яг л бидний түрүүн миний хэлээд байгаа улсын төсөв ДНБ-ий 30 хувиасаа хэтрэхгүй байвал макро эдийн засаг ер нь тогтвортой байна л гэж харж байгаа.

Р.Сэддорж: 4 номер нэмж хариулъя. Тодорхой товч хариул.

Н.Батнасан: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя.

Ерөнхийдөө манай 2 гол хөрш орны аль аль нь улс төрийн, цэрэг дайны болоод эдийн засгийн асуудлуудтай байна. Манай улсын импортын 60 гаруй хувь, экспортын 90 хэдэн хувь ноогддог 2 том хөрш орон хоёулаа асуудалтай байна. Хамгийн том асуудал юу байна вэ гэхээр нүүрсний үнэ. Одоо яах вэ нүүрсийг энэ компанитай уулзаж ярихад 48-90 доллар, дундаж үнэ 70 доллар хавьцаа байна. 73 орчим. Бид нар төсвөө хийхдээ 105 доллароор тооцчихсон байгаа. Тэгэхэд нийтдээ гадаад валютын нөөц 1 тэрбум орчим доллароор багасах ийм юутай байсан. Одоо тэгэхээр 70 руу очих юм энэ хэмжээ дахиад 1.6 тэрбумаар буурах ийм эрсдэл үүсэж байгаа юм. Төсөв дээр үүсэх эрсдэл төсвийн хэмжээ ойролцоогоор 3-4 их наяд орчим төгрөгөөр буурах.../минут дуусав./

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж байгаа тул Батнайрамдал гишүүн тодруулж асуулъя.

О.Батнайрамдал: Тодруулга юун дээр хийчихье Лхагвасүрэн Ерөнхийлөгч гаднын банк ингээд орж ирэх хүсэлтийг нь хүлээх юм хэн ч орж ирэхгүй л дээ. Тэгэхээр энэ дээр өөрсдөө бид нар ялангуяа Монгол шиг орон өөрсдөө хөөцөлдөж ажиллах ёстой юм л даа. Хөөцөлдөж ажиллахгүй бол хэн ч Монгол руу хүсэлт ирэхгүй. Монгол гаднын хөрөнгө оруулагчийн том радиуст нь байхгүй шүү дээ. Бид нар өөрсдөө актив ардаас нь хөөцөлдөн ажиллаж байж тэр радиуст орох юм. Тэгэхээр энэ дээр таны хариултыг би үнэхээр хангалтгүй гэж үзээд байна л даа. Тэгэхээр зүгээр хүсэлт ирээгүй гэдгээр ингээд та олон хариултын ам таглаж байна. Тэгэхээр энэ дээр арай жоохон өөр хариулт дараа нь сонсмоор байна. Яг тэгэхээр та энэ дээр нэмэлт хариулт өгөх үү? Тэгээд Батнасан багш дээр бас бас нэмэлт хариулт авчихъя. Тэгэхээр ер нь бид нар энд төсөв батлахад 26 оны төсөв батлахад ямар 3 зүйл дээр та анхаар гэж хэлж байгаа юм бэ л гэж асуугаад байгаа юм.

Р.Сэддорж: 3 номер.

Б.Лхагвасүрэн: Батнайрамдал гишүүний асуултад тодруулж хариулъя.

Тэгэхлээр өнөөдөр ингээд Монголын эдийн засагт байгаа гаднын хөрөнгө оруулалтын талаас нь ингээд харах юм бол жижиглэнгийн зах зээл дээр БНСУ-ын бизнесийн сүлжээ нэлээн идэвхтэй ажиллаж байгаа. CU дэлгүүр байдаг юм уу, GS25 дэлгүүр гээд, бусад гээд тэгэхлээр Солонгосын банкнууд энэ дээр сонирхолтой байх гэдгээрээ Солонгост уулзалт хийсэн. 2, 3 банкттай уулзалт хийсэн. Тэд нар бас судалгаагаа хийгээд түрүүчийн судалгааны багуудаа Монголд ирүүлсэн байгаа. Сая 4 сард банкны судалгааны баг ирж манай банкнуудтай уулзсан, аж ахуйн нэгжүүдтэй уулзсан байна лээ. Ерөнхийдөө эхний анхан шатны судалгаа нь хийгдээд эхэлчихсэн байна уу гэж харж байгаа.

Ялангуяа АНУ ч гэдэг юм уу, барууны томоохон орнууд руу бас очиж уулзалт хийж байгаа. Тэгэхлээр хамгийн гол нь тэдний асууж байгаа нь Засгийн газрын бонд дээр л илүү идэвхтэй ажилламаар байна. Хэрвээ дотоодын бондоо дотооддоо гаргаж эхлэх юм бол бид хэд танай зах зээл рүү.../минут дуусав./

Р.Сэддорж: 4 номер хариулах юм уу? 4 номер хариулъя.

Н.Батнасан: Төсвийн бодлого дээр 3 асуудал дээр төвлөрөх хэрэгтэй гэж бодож байна Нэгдүгээрт ер нь төсвийн зардлаа аль болох хумих асуудал. Ялангуяа бүтцийн өөрчлөлт хийх энэ асуудлууд дээр Нэгдүгээрт анхаарна.

Хоёрдугаарт, төр энэ төсөв ийн цоорхой үүсэж болзошгүй байгаа учраас, нэлээн том цоорхой үүсэж болзошгүй байгаа учраас төрийн өмчийн компаниудыг хувьчлах замаар тэндээс бас төсвийн орлогын тодорхой хэсгийг бүрдүүлэх ийм юм бодлого барьж болох байх.

Гурав дахь юм гаалийн татварыг ерөнхийдөө бас одоо бүгдийг нь жигд 5 хувьтай байгаа шүү дээ. Энийгээ бас ялгаатай байдлаар тогтоох замаар дотоодын үйлдвэрлэлээ ч хамгаалах, төсвийн талдаа ч гэсэн бас энэ цоорхойгоо тодорхой хэмжээгээр нь өгөх ийм зохицуулалт хэрэгтэй байна.

Р.Сэддорж: Жуковын Алдаржавхлан гишүүн асуулт асууна.

Ж.Алдаржавхлан: Ер нь Монголд ипотекийн зээлийг хэдэн банк, хэдэн хувийн хүүтэй, хэдэн жилийн хугацаатай олгодог юм бэ гэдэг асуултын нэгд хариулж өгөөч. Энэ сүүлийн үед орон сууцын үнийн өсөлт талийж байна л даа. Байрны үнэ чинь айхтар өсөж байгаа. Хэдэн арван саяар яригддаг болчихсон байна. Энэ үнийн өсөлт ер нь бодитой юм уу? Та хэд ер нь тооцоо судалгаа хийж үзсэн үү? Энэ эсвэл ипотекийн зээлийн олголттой хамаараад байна уу? Эрэлт, нийлүүлэлт маань ер нь хэр уялдаж байна орон сууцын энэ ипотекийн зээлийн салбарт? Монгол банкныхан яг юу гэж үзэж байгаа юм бол? Хаанаас ийм их жишээлбэл төлбөрийн чадвартай улсууд гарч ирж байрны худалдан авалт хийгээд байна? Эсвэл манай яг энэ Монголчууд аваад байна уу, эсвэл өөр гадна, дотноос хүмүүс аваад байна уу? Энэ ипотекийн зээлийн салбар дээр асуулт хариулж өгөөч гэж байгаа юм.

Хоёрт нь энэ валютын ханш маань ингээд тогтвортой байдал хамгийн чухал гэж байгаа. Ер нь энэ нүүрсний үнэ ер нь прогноз төлөв байдал хэр байгаа юм бол? Монгол банкнаас судалж л байгаа байлгүй дээ. Ер нь цаашид энэ уналт хэр зэрэг хугацаанд үргэлжлэхээр байна? Энэ дээр судалгаа байна уу? Хариулж өгөөрэй.

Гуравт нь өнгөрсөн жил бид нар Сангийн яам маань төсвийн зарлагаа 7 их наядаар нэмээд 25 хувь Монгол Улсын төсвийн зарлага ч нэмэгдсэн. Тэгээд та хэд болохлоор Монголбанкныхан болохлоор яг тэр үед болохгүй л гэж ярьж байсан. Тэгэхдээ та нарын үгийг хэн ч сонсоогүй. Тэгээд энэ жил Монголбанкныхан арай өөрөөр ажилламаар байна. Эдийн засгийн байнгын хороонд та хэд 9 сар гэхэд ерөнхийдөө төсвийн зарлагын өсөлтийг тэдэн хувь баривал зөв байна. гэдэг ийм тооцоо, судалгаагаа өгөхгүй бол манай Сангийн яамны улс төрчдийн захиалгаар Сангийн яамныхан маш их хэмжээгээр нь төсвийн зарлага нэмдэг. Тэр нь эргээд валют болж гадагшаа урсдаг. Тэгээд цоорхой үүсэх гээд байна гээд байна шүү дээ. Тэр төсвийн зарлага дээр ер нь Монголбанкныхан энэ минийх, надад хамааралгүй гэдэг талаас биш Монгол Улсын төлбөрийн тэнцлийг барьж байгаа байгууллага маань энэ төсвийн зарлага дээр жоохон санаа зовж энэ намар гэхэд Эдийн засгийн байнгын хороон дээр ер нь иймэрхүү байдлаар төсөв дээр ингээд саналаа өгч өгч баймаар байна.

Яагаад гэхээр Засгийн газар та бүгдийн саналыг бараг манай энэ Жавхлан сайд маань авч хэлэлцдэг юм уу, үгүй юү бараг? 7 их наядаар нэмэгдэнэ гэдэг чинь маш өндөр өсөлттэй л нэмэгдсэн байгаа байхгүй юу төсвийн зарлага. Энэ дээр та хэд маань бас санал гаргаж өгч байгаач, энэ дээр ер нь ямар бодолтой байна гэсэн 3 асуулт дээр эхлээд хариулчих. Тэгээд дараа нь би нэмж асууя.

Р.Сэддорж: Хариулт 3 номер Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя. Тэгэхлээр энэ ипотекийн хөтөлбөрийг 2013 оноос хойш ингээд Монголбанк өөрөө анх санаачлаад хэрэгжүүлээд явж эхэлсэн байгаа. Тэгээд ингээд бараг 12 жил болж байна. Энэ 6 хувийн хөнгөлөлттэй хүүгийн хөтөлбөр байгаа юм. Тэгэхлээр өнөөдөр банкны зах зээлийн жирийн зээл олгодог хүү бараг дундаж нь 17 хувь байхад энэ 16 хувийн хөнгөлөлттэй хүү маш их хөнгөлөлттэй хүү учраас эрэлт маш өндөртэй байдаг. Би хамгийн сүүлийн тоонуудыг танд хэлэх гэж байна. 2025 оны 5 сарын 30-ны байдлаар Монголбанк болон банкны эх үүсвэрээр нийт 521.9 тэрбум төгрөгийн зээлийг 4.2 мянган өрхөд олгосон байгаа. Энэ нь өмнөх оны үеийнхтэй харьцуулах юм бол санхүүжилт нь 1.4 хувиар өссөн байгаа хэдий ч өрх, нөгөө зээл авсан өрх нь өөрөө 5.8 хувиар хорогдчихоод байгаа юм. Энэ өөрөө цаанаа юу хэлж байна. гэхлээр орон сууцын үнэ өсөөд байна. Тэр утгаараа мөнгөн дүн нь өсөж байгаа ч гэсэн байранд орж байгаа хүнийх нь тоо буурч байгаа ийм прогноз, хандлага харагдаад байгаа юм.

Үүнээс ингээд энийг нь дотор нь Улаанбаатар, орон нутаг гэж ялгах юм бол Улаанбаатар хотод 341.9 тэрбум төгрөгийн зээлийг 2.6 мянган өрхөд, орон нутагт 180 мянган төгрөгийн зээлийг 1.6 мянган өрхөд ингээд олгоод байж байгаа юм. Тэгээд өмнөх онтой харьцуулах юм бол орон сууцын үнэ 13 хувиар өссөн ийм бас судалгаа байгаа. Тэгэхлээр орон сууцын үнэ жилийн хугацаанд 13 хувиар өссөн байна гэсэн ийм.

Ханшны хувьд яг л таны түрүүн хөндсөн тэр нүүрс, нүүрсний тоо хэмжээ үнэ буурсан учраас Монголд орж ирэх валютын орлого маань буураад байгаа учраас ханш дээр тодорхой хэмжээний дарамттай байгаа. Нүүрсний үнийн хувьд бол ерөнхийдөө ингээд тоо хэмжээг нь харахлаар өмнөх онтойгоо ойролцоо юм шиг харагдаад байгаа юм.

Тэгэхдээ энэ нь чанарын хувьд өөрчлөгдчихөөд байгаа юм. Коксождог буюу нөгөө төмөр боловсруулахад зориулсан өндөр үнэтэй нүүрс нь багасаад, эрчим хүчний буюу хямд үнэтэй нүүрснийх нь хэмжээ нэмэгдчихээд байгаа юм. Энэ утгаараа дундаж үнэ нь ч буурчихсан ийм зүйл. Орлого маань өөрөө бараг нүүрс дээрээ 2 тэрбум доллароор, 2 тэрбум доллароор тасраад явж байгаа. Энэ нь өөрөө худалдааны тэнцэл болон төлбөрийн тэнцэл дээр дарамт үүсэх гээд л ингээд явж байгаа юм. Энэ ийм асуудал байгаад байгаа юм.

Таны сүүлийн гурав дахь асуултын хувьд бид бас манай Монголбанк дээр төсвийн тогтвортой байдал хамт бас ингээд суугаад ажиллаж байгаа. Төсвийн тогтвортой байдалтайгаа нэлээн бас ойрхон ярьж байгаа. Тэр утгаараа 9 сард Монголбанк тодорхой тооцоо, судалгаа хийгээд өгч болно гэж.

Нүүрс ер нь өнөөдрийн тэр дундаж 70 гээд байгаа үнэ КОВИД-ын өмнөх үнийнхээ яг тэр түвшин рүү оччихож байгаа юм. Тэгэхлээр яг КОВИД-ын буюу нэлээн тийм өндөр өсөж байсан 100, тонн нь 100 доллароос давж байсан үеэсээ.../минут дуусав./

Р.Сэддорж: Алдар Алдаржавхлан гишүүн тодруулж асууя.

Ж.Алдаржавхлан: Лхагвасүрэн Ерөнхийлөгч би 1 зүйл дээр л болгоомжлоод би хуучин бас Орон сууцын санхүүжилтийн корпорацын захирлаар ажиллаж байсан. Монголд анх удаа 8 хүүдийн хүүтэй зээлийн хөтөлбөр эхлүүлж байсан. Та мэдэж байгаа төрийн албан хаагчдын 4000 айлын гээд. Анх удаа бид нар 11 онд энийг хийж байсан. Тэгээд эрэлт, нийлүүлэлттэй уялдуулахгүй бол ерөөсөө болдоггүй юм л даа энэ орон сууцын үнэ. Тэгээд ипотекийн зээлийн эх үүсвэрийг маш болгоомжтойгоор энэ зах зээл рүү оруулж ирэхгүй бол орон сууцын үнэ асар их хурдтай өсөөд та бүгд бүгдээрээ мэдэж байгаа.

Тэгэхлээр тэр Хуримтлалын сангаас орж ирэх гэж байгаа хөрөнгө болгоныгоо бүгдийг нь ипотекийн зээл болгох шаардлагатай юу, үгүй юу? Тийм хууль эрх зүйн орчин байдаг юм уу, үгүй юм уу? Та хэд ер нь яг ипотекийн зээл энэ орон сууцын үнийн өсөлт дээр ер нь ямар бодлого барья гэж бодоод байна? Энэ чинь ингээд хязгааргүй өсөхөөр байна шүү дээ. Ингээд 10, тэр 10 хувь чинь худлаа байх. 3 сая байсан байшин 4 сая болчихсон л байна лээ. Метр квадрат нь 5, 6 сая болчихсон л байна лээ. Ингээд асар.../минут дуусав./

Р.Сэддорж: Хариулт 3 номер.

Б.Лхагвасүрэн: Алдаржавхлан гишүүний асуултад тодруулж хариулъя. Тийм 13 хувь гэдэг нөгөө хуучин, шинэ байшин бүх л юмны дундаж үнэ л дээ. Тэгэхлээр үнэтэй байр, байршлаасаа хамаараад янз бүр байгаа учраас 13 гэдэг тун зарим газар нь өндөр байгаа, зарим газар нь нам доор байгаа. Ер нь ипотекийн зээл авах тэр хүсэлт буюу эрэлт маш өндөр байгаа. Одоо манай банкны систем дээр бараг 1 их наядын ийм хүсэлт нь ирчхээд байгаа. Тэгэхлээр нэгэнт очер, дэс дараа үүсээд явж байгаа учраас энийг хэрвээ ингээд зогсоож юм уу, ямар татах хэмжээнд авах юм бол бас л жоохон төвөгтэй байдал үүснэ л гэж харж байгаа юм.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж байна. Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Тийм тийм. Тэгэхдээ та хэд маань ойлгоорой. Энэ чинь нөгөө эрэлтийг санхүүжүүлээд л байх юм бол орон сууцын үнэ чинь өсөөд л байна. Тийм учраас тэр эрэлт маш их байхын хэрээр маш их хэмжээний санхүүжилт өгөх юм бол бид нар орон сууцынхныг барьж чадахгүй байхгүй юу. Тэгэхлээр Монголбанк бодлого гаргаач. Хэдий хэмжээний ипотекийн зээлийн эх үүсвэр зах зээлд байж байж бид нар орон сууцынхаа үнийн өсөлтийг барьж чадах вэ гэдгийг л та хэд маань тийм прогноз надад хэлж өгөөч. Иймэрхүү хэмжээний эх үүсвэр зах зээлд байх юм бол бид нар орон сууцын өсөлтийг жилд нь бариад байх юм гэж. Тийм тоо эд нар байна уу, үгүй юу?

Р.Сэддорж: Хариулт 3 номер.

Б.Лхагвасүрэн: Бидэнд мэдээж тоонууд байгаа.

Тэгээд КОВИД-ын өмнөх тоо, жишээг л дурдахад 2017 онд орон сууцын үнэ 5 хувиар өсөж байсан. Тэр үед 5 хувиар буурч байсан орон сууцын үнэ буурсан тохиолдол байгаа 2017 он. Тэр үед санхүүжилтийн хэмжээ нь 500 тэрбумаар яг хэмжигдэж байсан. Одоо өнгөрсөн онд 1.2 их наяд гэдгээрээ санхүүжилт 2-оос илүү дахин өсөж л байгаа. Тэгэхлээр эх үүсвэрийг нь танаж өгвөл мэдээж эрэлт бол орон сууцын үнийн өсөлтийг хязгаарлах боломж байгаа л гэж.

Р.Сэддорж: Алдаржавхлан гишүүн бол энэ өндөр үнээр орон сууц зарагдаад байна л гэж хэлээд байна шүү дээ тийм ээ? Тэгээд үүний эх үүсвэр хаанаас байна вэ л гээд. Энэ бол тодорхой хариулах зүйл байх. Ингээд Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууна.

Б.Жаргалан: Макро эдийн засгийн байдал бас хүндэрч болзошгүй байгаа талаар нэлээн ярьж байгаа. Төсвийн орлого тасалдсан, нүүрсний үнэ унасан. Монголбанканд хамааралтай 2 зүйл байгаа валютын ханш, инфляц. Доллар 3600 давчихсан байж байна. Сүүлийн үед юанийн ханш 500 гараад явчихлаа шүү дээ. Тэгээд энэ бол маш их бас болгоомжлол төрүүлж байна.

Яагаад гэхлээр худалдааны салбарынханд бас хүнд цохилт болж байна. Ялангуяа импортлогчид нарт гэдэг юм уу. Инфляц 2 оронтой тоо руу орж болзошгүй болоод явчихлаа. Тэгэхээр яг энэ цаг мөчид энэ Эдийн засгийн байнгын хорооны гишүүд та бүхнээс, Монголбанкны Ерөнхийлөгчөөс бодлогын манлайлал хүсээд байгаа юм. Тэгээд энэ макро эдийн засгийн асуудал дээр ийм бодлогын манлайлалтай ажиллаад өгөөч ээ, яг энэ төрлийн зүйл яриач гэдгийг гишүүд маань удаа дараалан асуулаа гэж харж байна. Тэгсэн чинь Монголбанкны тайлан яаж орж ирж байна вэ гэхлээр, тэгсэн чинь Монголбанкны тайлан яаж орж байна вэ гэсэн чинь Аппл пэй/Apple pay/ нэвтрүүлээ онцлох үйл явдал. Ерөнхийлөгч тийм хуралд хамрагдлаа. Тэгээд энэ бас ийм бодлогын манлайлал ерөөсөө огтхон ч биш байна.

Тэгэхээр та бүхэн маань энэ хүмүүсийн яриад байгаа шүүмжлэлийг бас хүлээж аваад тэгээд зүгээр ийм Засгийн газрын ийм дохиураар биш, үнэхээр яг ийм мөнгөний бодлогын хараат бус байдлыг хадгалаад тэгээд энэ макро эдийн засгийн бодлого дээрээ бас ийм дорвитойхон шиг санал, онол уралдуулаад Их Хуралтайгаа бас нягт хамтарч ажиллаад тэгж ажиллаач гэж хүсэж байна. Тэгээд тэрийг бас жоохон ойлгоосой гэж бодоод байна. Тэгэхгүй ингээд хэдэн асуултад ингээд хариулчихдаг юм, тэгээд ар дээр нь энийг тайлангаа батлуулаад яваад өгнө гэсэн тийм бодолтой баймааргүй байна. Тэгээд өнгөрсөн ер нь Лхагвасүрэн Ерөнхийлөгчийг томилогдсоноос хойших хугацаанд Монголбанкны энэ бодлогын манлайлал огт харагдсангүй. Дандаа л ийм Засгийн газрын карма шиг л ингэж явж ирлээ.

Тэгээд сая Энхтүвшин гишүүний асуултад та бас хариулахдаа хэллээ хөтөлбөрийн зээлүүд дээр Монголбанкны баланс дээр 3.6 их наяд төгрөгийн дүн байгаа гэж хэлж байна. Энэ дүнг бүүр задаргаатай нь одоо хэлмээр байна. Тэгээд дараа нь бичгээр бас ирүүлмээр байна. Яг ямар ямар төсөл, хөтөлбөрүүд яваад байгаа юм? Тэр Эрдэнэс Монгол дээр байгаа зээл байгаа юм байна, бусад энэ Хүнсний хувьсгал гэх мэт хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрүүд байгаад байгаа юм байна. Тэрийгээ бүүр ингээд бүрчлэн дурдахыг хүсэж байна. Сая төсвийн хүрээний мэдэгдэл батлагдсан. Тэгээд алдагдалгүй төсөв гэсэн концепц чинь явж байна.

Гэхдээ энэ бас хэр зөв юм, буруу юм гэдгийг бас гишүүд бас яриад байгаа. Валютын орох урсгал дээр ер нь бид нар юу бодох юм бэ? Энэ зэс, нүүрсний.../минут дуусав./

Р.Сэддорж: Жаргалан гишүүн 1 минут.

Б.Лхагвасүрэн: Уул уурхайн түүхий эдийн үнэ буурч байгаа энэ цаг мөчид энэ валютын орох урсгал дээр бас ямар бодлогууд барьж байна? Сая жишээлбэл

Хөгжлийн банк 500 сая ам.долларын бонд гаргамаар байна гэсэн зүйл арга хэмжээн дээр бас яриад явж байсан. Энэ ТӨК-уд дээр бас янз бүрийн ямар боломжууд байгаа юм ч гэдэг юм уу энэ талаар та нарын бас судалж байгаа зүйлүүд байна уу? Хяналтын зөвлөлийн гишүүдэд хандаж хэлмээр байна та бүхний ирүүлсэн дүгнэлт хангалтгүй байна. Тэгээд бүх гишүүд нь бас орж ирээгүй байна. Зөвхөн Ууганбаатар дарга л ирсэн байна. Тэгээд бид нар энэ аудитын тайлан энэ тэрээс унших зүйлээ бас та бүхнээс хүсэхгүй байгаад байна шүү дээ. Та нар маань ингээд бүүр ул суурьтай ажиллаад нэлээн тийм нөгөө дорвитойхон шиг дүгнэлтүүд өгмөөр байна. Санхүүгийн тайлан чинь 5 жил дараалаад хязгаарлагдмал дүгнэлттэй гарчихсан. Хяналтын зөвлөл саяхан томилогдоод сонсгол хийгээд байсан. Тэгээд энэ дүгнэлтүүдээ бас жаахан чамбайруулаад шаардлагатай бол энэ Эдийн засгийн байнгын хорооны гишүүдтэйгээ тусад нь уулзаад, өөр хурал зохион байгуулаад тэгээд тийм арай өөр түвшинд.../минут дуусав./

Р.Сэддорж: Хариулт 3 номер.

Б.Лхагвасүрэн: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Ерөнхийдөө Монголбанкны мөнгөний бодлогоор бид инфляцыг л тогтворжуулах л ийм зорилтыг л л зориод явж байгаа. Тэгээд бодлогын хүү өнөөдөр 12 хувь байна. 12 хувь нэлээн хатуу өндөр хүү гэж бод болно. 4 сарын эцсийн байдлаар инфляц 8.6 буюу манай зорилтот түвшний 8 хувьтай ер нь нэлээн ойролцоо ингээд гарч ирсэн байгаа.

Тэгэхлээр бид зорилтот түвшин буюу 8-аасаа дотогшоо оруултлаа мөнгөний хатуу бодлогоо ингээд баримтлаад л явна гэж харж байгаа юм. Тэгэхлээр ингээд 6 сард манай Мөнгөний бодлогын хороо хуралдана. Ерөнхийдөө мөнгөний бодлогынхоо бодлогын хүүг нааш хөдлөх үү, хөдлөхгүй юү гэдгээр ингээд энэ дээрээ хэлэлцээд явна.

Ханш бол оны эхнээс 4.7 хувиар суларчхаад байгаа. Ерөнхийдөө энэ ханшны энэ сулрал өөрөө таны дурдаж байгаа ялангуяа тэр гадаад худалдаан дээр, нүүрсний экспорт дээр орлого тасалж байгаатай шууд холбоотой гэж харж байгаа. Тэр утгаараа ч гэсэн оны эхэнд төлбөрийн тэнцлийн алдагдал бараг 900 сая доллартой тэнцэж байсан бол одоо ингээд буугаад явж байна. 4 сарын эцсийн байдлаар 480 сая болж доошоо буурч байгаа.

Хэрвээ нүүрсний экспорт хэвийн хэмжээнд очих юм бол төлбөрийн тэнцэл, гадаад худалдааны тэнцэл эргээд хэвийн байдалдаа орно, валютын нөөц нэмэгдэнэ, ханш илүү тогтвортой байна л гэж харж байгаа юм. Ер нь яах вэ бодлогын манлайллын хувьд яг сая 24 оноос эхлээд Монгол Улсын эдийн засаг, нөгөө КОВИД болон геополитикийн хүнд нөхцөлтэй байдлынхаа араас л гарч ирж байгаа юм л даа. Тэгээд 2020-2022 оны хувьд Монголбанк ялт ч байхгүй Засгийн газартай КОВИД-ын бодлого дээрээ энэ нэгдсэн бодлого ингээд ажилласан. Дараа нь 2022 оны 2 сараас эхлээд Орос, Украйны дайнтай холбоотойгоор хүндрэл үүссэн учраас энэ дээрээ бас бодлогын уялдаагаа нэлээн ойролцоо ажиллаж эхэлсэн байгаа. Одоо энэ оноос эхлээд Төв банкны хувьд илүү бие даасан бодлого баримтлах боломж нь гарч ирж байна л гэж харж байгаа.

3.6 тэр андуурсан тоо. Тэр хөтөлбөрийн зээлийн дүнг хэлэхдээ тэр нөгөө Монголбанкныхаа саяын юутай хамт авлага гээд андуураад хэлсэн нь буруу

ойлголт яасан байна. Тэгэхлээр Монголбанкн дээр ийм өр, авлага байхгүй. Зөвхөн саяын Энхтүвшин гишүүний асуусан тэр 2 том л авлага л байгаа.

Р.Сэддорж: Хяналтын зөвлөл хэдэн номер байна? 5 номер тодорхой хариулаарай.

Ууганбаатар: Хяналтын зөвлөлийн дарга Ууганбаатар. Жаргалан гишүүний шүүмжийг хүлээж авлаа. Тэгээд дараагийн удаа илүү өөрийн чинь хэлснээр чамбай дүгнэлт оруулж ирэх дээр онцгойрон ажиллая. Ер нь ярилцвал ярилцах асуудал нэлээн байгаа гэж дотроо бодож байгаа. Тэн дээр бас санаачилга гаргаад ярилцах нь зөв болов уу гэж бодож байна. Тэр саналыг бас хүлээж авч байна.

Р.Сэддорж: Жаргалан гишүүн хариулт хангалтгүй байна гэж үзэж байна. 1 минут.

Б.Жаргалан: Өнгөрсөн онд зудтай холбоотойгоор малчдын зээлийн эргэн төлөлтийг бас хойшлуулсан байж байгаа. Тэр эргэн төлөлт одоо бол хэвийн төлөгдөөд эхэлчихсэн гэж ойлгож байгаа шүү дээ тээ? Сая энэ хавар болохлоор бас ноолуурын асуудлууд бас гарсан. Ер нь энэ малчдын зээлийн эргэн төлөлт хэр байгаа вэ? Ер нь энэ хөдөө аж ахуйн салбар маань бас яг сэргэх ямар боломж, бололцоонууд харагдаж байна вэ гэдэг дээр бас тайлбар авъя.

Р.Сэддорж: Хэдэн номер вэ? 3 номер Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Нийт энэ 4 сарын эцсийн байдлаар нийт малчны зээлийн үлдэгдэл 1.3 их наяд, 1 их наяд 287 сая байна. Нийт зээлдэгч нь 138 мянган малчин байгаа. Тэгэхлээр энэ ерөнхийдөө өнгөрсөн онтой харьцуулах юм бол буураад явж байгаа.

Р.Сэддорж: Хариулт болсон уу? Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Байнгын хорооны гишүүндээ өнөөдрийн мэндийг хүргэе. Ямар ч байсан Монголбанк 2024 онд 300 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь сайн байна. Гэхдээ энэ маань баланс дээр яаж тусчхав гээд би сонирхолтой асуулт асуумаар байгаа юм.

Яагаад гэхээр хуримтлагдсан алдагдал маань ингээд бараг 50 тэрбум өсчхөөд байдаг, бусад нөөц гээд өсчхөөд байдаг. Яаж хуваагдсан бэ гээд нэгдүгээр асуулт байна.

Нөгөө талдаа Монгол Улсад зээлийн хүү өндөр байна. Яагаад зээлийн хүү өндөр байна вэ гэхээр зээлийн эрэлт нь дотоод эх үүсвэрээсээ маш өндөр байгаатай холбоотой. Нөгөө талдаа манай улсын эдийн засаг маань ингээд 2 хөршийнхөө эдийн засагтай хэр холбоотой байдаг вэ гээд ингээд ийм олон асуудлаас эдийн засгийн салбараасаа хамаараад олон асуудлаас хамаарч байгаа. Тэгэхээр Монголбанкныхаа мөнгөний бодлого улсуудаас энэ манай Монголын эдийн засгийн Хятад, Оросын эдийн засгаас хамаардаг хамаарал буюу корреляци маань хэдэн хувь байдаг юм бэ гэж? Монгол Улсын дотоод хуримтлал бага байгаа учраас бид нар зээлийн эрэлтээ дийлэхгүй. Зээлийн хүү маань өндөр байгаад байна. Тэгвэл сүүлийн 5 жилд төлбөрийн балансаар дамжиж гадагшийгаа хэдий хэмжээний мөнгө гарч байршсан бэ гэдэг асуулт байна. Хоёрдугаар асуулт.

Гуравдугаар асуулт болохоор энэ 2024 онд захиргааны ба үйл ажиллагааны зардал нь 2024 онд 2023 оноосоо бараг 56 хувиар өссөн юм байна. Энийг дэлгэрэнгүй тайлбарлаж өгөөч. Бодлогын чанартай зардлын өсөлт хэдэн хувь байсан юм бэ? Хүний нөөцтэй холбоотой өсөлт хэдэн хувь байсан юм бэ гээд?

Дээрээс нь болохоор энэ Монголбанкны балансыг Монголын банкны үндсэн зорилго үндэсний мөнгөн тэмдэгтийн төгрөгийн тогтвортой байдлыг хангах зорилготой уялдсан зээлийн хүүгийн болоод бусад зарлагын, зардлын задаргаагаар харвал яаж харагдах вэ Монголбанкны балансыг шүү? Зээлийн хүүг бууруулах бодлогын хүрээнд гаргасан зээлийн хүүгийн болоод бусад зардлын задаргаа хэд вэ гэж байна? Үйл ажиллагааны зар талаас нь асууж байгаа юм.

Нөгөө талаасаа Монголбанкны балансаа бодлогын баланс үүнээс төгрөгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр баланс маань яаж задрах юм? Зээлийн хүүг бууруулах бодлогын хүрээнд баланс маань яаж задрах юм, ханшийн бодлогын хүрээнд баланс маань яаж задрах юм бэ гэдэг ийм асуудлыг энэ асуумаар байна. Энэ тал дээр манай Монголбанк маань энэ тал дээр ямаршуу бодлого байна, манай Хяналтын зөвлөлийнхөн ингээд балансаа иймэрхүү байдлаар задалж харж байх ёстой байх гэж бодож байгаа юм. Тэгээд бусад улсын Төв банк бол олсон ашгаасаа Засгийн газартаа ногдол ашиг өгдөг. Манай Монголбанк хэзээ ногдол ашиг өгдөг болох юм бэ? 7.5 их наядын алдагдалтай яваад байгаа. Тэр дүрмийн сангаа 2026 онд ч юм уу хэдээр нэмэгдүүлэх юм? Тодорхой төлөвлөгөө гаргаж ажиллахгүй бол хэдүүлээ ийм өндөр нийт балансынхаа 25 хувийн алдагдалтай ийм баланстай байж болохгүй. Тэгэхээр энэ дээр ямар бодлого барьж байгаа гэдэг ийм асуултууд байна?

Р.Сэддорж: 3 номер хариулт.

Б.Лхагвасүрэн: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Санхүүгийн тайлан дээр тэр өөрийн хөрөнгө гэсэн хэсэг байгаа. Энэ өөрийн хөрөнгө хэсгийн тэр дүрмийн сан нь 60 тэрбум, хуримтлагдсан алдагдал гэдэг нь өнөөдрийг хүртэлх Монголбанк, ер нь Монголбанкны алдагдал 12 оноос эхэлсэн байдаг статистикийн тайлангаараа. Тэгээд хуримтлагдаж явсаар байгаад энэ 7.4 болчихсон байгаа. Өнгөрсөн оны 300 тэрбум төгрөгийн ашиг энэ дээр өнөөдрийн энэ оны ашиг алдагдал гэсэн хэсэг дээр байгаа. Он гарсны дараа буюу 25 оны санхүүгийн тайлан дээр хуримтлагдсан алдагдал руугаа орох учраас хуримтлагдсан алдагдлын хэмжээ нь саяын энэ оны ашгаараа буураад явах юм. Тэгэхлээр санхүүгийн тайлан дараа он дээрээ саяын нөлөө нь ингээд орж ирнэ гэж харж байгаа.

Нийт энэ 2024 оны 12 сарын 31-нээр Монголбанкны өөрийн өрийг -4.8 их наяд. Энэ маань өөрөө саяын алдагдалтай хэсгийг хасаад л орж байгаа учраас ингэж харагдаж байгаа. Монголбанк хэрвээ бодлогын хүүгийн зардлаа багасгах, ялангуяа тэр Хятадын Ардын банкныхаа өрийг төлж дуусгах юм бол хүүгийн зардал бас буурах. Тэгэхлээр нийт алдагдлын 60 гаруй хувь нь бодлогын хүүгийн зардал буюу төв банкны үнэт цаасны хүүгийн зардал эзэлж байгаа юм. Тэгэхлээр төв банкны үнэт цаасны хэмжээ багасах, хүү багасах хэмжээгээр энэ бодлогын зардлын зардал буурна. Тэгэхлээр энэ үүгээр ингээд буурах боломжтой. Хятадын Ардын банкны свопын өрийг төлж дуусгах юм хүүгийн зардал гарахгүй учраас буурна.

Своп хэлцлүүд байдаг. Банкнуудтай гаднаас орж ирж байгаа эх үүсвэрийг нь Монголбанк өөр дээрээ аваад төгрөгийн эх үүсвэр нийлүүлж явж байгаа. Энэ дээр бас 33 хувийн ийм зардал гарч явж байгаа. Нийт зардлын 33 хувь нь энэ хэсэг дээр байгаа учраас тэгэхлээр энэ яваандаа своп хэлцлийг багасгах юм бол бас энэ свопын зардал буурах боломжтой боломжтой. Тэгэхлээр зардлыг бууруулах орон зайнууд байгаа. Энэ дээр Монголбанк ингээд ажиллаад явж болно.

Монголбанкны хүүгийн орлого гэдэг нь юу вэ гэхлээр валютын нөөцийг олон улсад удирдаад орж байгаа тэр хүүгээс олж байгаа орлого байгаа. Хүүгийн зардал хэсэг нь болохлоор миний саяын хэлсэн бодлогын хүүгийн зардал байгаа юм. Тэгэхлээр банкин дээр байдаг тэр хүүгийн орлого, зарлага гэдэг хэсэг нь Монголбанкна дээр болохлоор бодлогын хүүгийн зардал, валютын нөөцийг удирдаж байгаа хүүгийн орлого гэсэн энэ 2 хэсгээс л ингээд бүрдээд явж байгаа.

Хоёр дахь асуултын хувьд 2 хөрштэй өндөр хамааралтай. Монгол Улсын экспортын 90 гаруй хувь нь БНХАУ буюу урд хөрш рүү гарч байна. Урд хөршөөс эргээд 30 хувийн манай импорт бас хамааралтай байгаа. ОХУ-аас манай импортын 30 хувь. Тэгэхлээр 2 хөрштэйгөө экспорт бараг 90, 60 гэсэн харьцаа. Түрүүн Батнасан доктор бас хэлж байсан. Экспортын 90 хувь 2 хөрш рүү, импортын 60 хувь 2 хөршөөс орж ирж байна.

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя 3 номер.

Б.Лхагвасүрэн: Тэгээд маш өндөр хамааралтай гэдэг нь. Тэр утгаараа ч тэр одоо ер нь экспортын, нийт экспортын 93 хувь нь түүхий эд байгаа. Нүүрс, зэс, алт, төмрийн хүдэр гээд гэх мэтчилэн. Тэгэхлээр энэ нь өөрөө нэг зах зээл рүү гарна гэдэг маань нэг зах зээлээсээ маш их хамааралтай байна л гэсэн үг. Хэрвээ тэр зах зээлд нь эрэлт нь буурах юм бол үнэ тэр хэмжээгээр буураад шууд манай эдийн засагт нөлөөгөө үзүүлнэ гэсэн үг. Нэг зах зээлээс бас шууд бүтээгдэхүүнээ буюу шатахуун тослох материалын эрчим хүчийг нэг зах зээлээс авч байгаа. Тэгэхлээр тухайн зах зээлээс нийлүүлж байгаа үнэ өөрчлөгдөхөд манай эдийн засаг дээр бас тэр хэмжээний шок нь ингээд шууд орж ирнэ л гэж хэлж болно.

Р.Сэддорж: Гишүүд санал хураалт байгаа. Ажлын хэсэг байгуулах тухай санал хураалт байгаа.

Соронзонболд гишүүн тодруулж асууя

Л.Соронзонболд: Ингээд байна л даа. Монгол Улс нийт зээлийнхээ 70 хувийг дотоодоосоо хангаад, үлдэх 30 хувийг гадаадаас бид нар зээлж аваад байна. Тэгэнгүүт бас Монгол Улс мөнгөгүй юм уу гэхээр мөнгөгүй биш, гадагшийгаа бас мөнгө ингээд төлбөрийн балансаар гараад байна шүү дээ. Тэгэхээр би сүүлийн 5 жилд төлбөрийн балансаар дамжиж гадагшаа байршсан хөрөнгө маань хэд байдаг юм болоо гээд байгаа байхгүй юу. Тэр байршиж байгаа хөрөнгө маань өөрөө Монгол Улсын эдийн засагт хүмүүсийн үзүүлж байгаа итгэл үнэмшлийн асуудал байна. Тэр маань ямаршуу байдаг юм бэ? Энийгээ манай Монголбанк маань хэмжиж байна уу гэж асуугаад байхгүй юу. Тэгээд би энэ баланстайгаа ингээд та хэд бодлогын баланс, ханшийг нь ханштай холбоотой баланс гээд задалбал яаж харагдах юм бэ гээд асуугаад байна шүү дээ. Тэгээд энэ талаар та хэд асуултад гүйцэд хариулчхаач. Дүрмийн санг нэмэгдүүлэх талаар ямар төлөвлөгөө байгаа юм бэ гээд асуугаад байгаа юм.

Р.Сэддорж: 3 номер хариулъя.

Б.Лхагвасүрэн: Соронзонболд гишүүний асуулт тодруулж хариулъя. Ер нь 12 арилжааны банк өөрийнхөө позицийг буюу гадаад валютынхаа хэсгийг удирдахдаа пассиваар авч өгсөн мөнгөний тодорхой яг тэрэнтэй нээлттэй позицоороо бас тодорхой яг тэрэнтэй ойролцоо хэмжээний мөнгийг гадагш нь байршуулж л байгаа л даа. Тэгэхлээр бидний зүгээр банкны санхүүгийн тайлан дээрээс хараад авсан мэдээллээр 1 тэрбум орчим долларыг гаднын арилжааны банкнууд дээр байршуулж байгаа. Энэ нь тухайн банкны хувьд харилцагчийнхаа төлбөр тооцоог хийхэд зориулагдаад тэнд ингээд байршаад явж байдаг. Мөн гаднаас Монгол руу ингээд харилцагчаар нь дамжиж орж ирэхэд хамгийн түрүүнд тэр гадаадынх нь банкных нь харилцах дансанд байршиж байгаа юм.

Тэгэхлээр ер нь ойролцоогоор 1 тэрбум орчим доллар байгаа гэсэн статистик тоо байгаа. Монголбанкны энэ санхүүгийн тайлан дээр бодлогын буюу тэр үйл ажиллагааных нь хэсгээр ингээд ялгах юм бол ер нь миний түрүүчийн хэлсэн манай хүүгийн алдагдлын л хэсэг байгаа л даа. Нийт зардлын 66 хувь нь бодлогын хүүгийн зардал буюу Төв банкны үнэт цаас. Энэ бол бодлогын.../минут дуусав./

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя. Баланс асууж байна.

Б.Лхагвасүрэн: Баланс маань өөрөө ингээд энэ олон улсын нягтлан бодох бүртгэлийн яг л тэр стандартын дагуу явж байгаа юм. Тэгээд хамгийн сүүлд нэвтэрсэн Ай Эф Ар Эс -9/IFRS-9/ буюу олон улсын санхүүгийн тайлагналын 9 дүгээр стандартаар энэ ингээд бүртгэлээ бүгдийг нь хийгээд явж байгаа. Одоо та бүхэнд тараагдсан материал дотор хөрөнгө гээд буюу актив хэсэг байгаа. Энэ дотор байгаа тэр бэлэн мөнгө, гадаадын банк бус санхүүгийн байгууллагууд байршуулсан хөрөнгө ч гэдэг юм уу, дотоодын банкнуудад олгосон зээл ингээд эд нар бүгдээрээ манай нөгөө актив хэсэг.

Тэгэхлээр тэр гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хэсэг манай удирдаж байгаа нөөц маань байгаа. Мөн Эрдэнэсийн сангийн хэсэг байна. Алт, үнэт металл буюу дотооддоо хадгалж байгаа хэсэг, мөн гадаадад хадгалж байгаа хэсэг, тодорхой хэмжээний Засгийн газрын үнэт цаасыг Монголбанк авсан бол ингээд байршил явж байгаа. Тэр гүйлгээнд гаргасан мөнгө маань манай пассив өр төл.../минут дуусав./

Р.Сэддорж: Тодруулж хариулах уу, нэмж хариулах уу? 3 номер.

Б.Лхагвасүрэн: Тэгээд энэ Монголбанкны 4 сая 60 тэрбум төгрөг. Энэ бол 2019 онд Монгол, төв банкны тухай хуульд өөрчлөлт оруулахдаа 100 тэрбум төгрөг хүртлээ нэмж болно гэдгээр ингээд өөрчлөлт оруулсан юм байгаа юм. Тэгээд тийм л тоо байгаа. Тэгэхлээр ер нь Төв банк дүрмийн сангийнхаа тоо хэмжээг заахдаа Их Хурлаас зөвшөөрөл авдаг.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж байна. Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Одоо тэгээд энэ бид нар ингээд 30 их наядын баланстэй. Тэрнийхээ 7.5 их наядын алдагдалтай ингээд явж байж болохгүй дээ. Арилжааны банк 100 тэрбумын дүрмийн сантай шүү дээ. Монголбанк болохоор 60 тэрбумын

дүрмийн сантай. Тэгэхээр бид нар 2026 оны төсөв дээр ч юм уу Засгийн газарт ингээд чиглэл өгөөд энэ дүрмийн санг нэмэгдүүлж төлөвлөгөөг гаргах ёстой байхгүй юу. Тэгээд 500 тэрбум байх юм уу 200 тэрбум байх юм уу тээ? Энэ дээр Монголбанк ажиллах ёстой байх л гэж бодоод байна.

Түрүүн Алдаржавхлан гишүүний асуугаад байгаа тэр хөрөнгийн үнийн хөөсрөлтийн тухай асуудал ярьсан шүү дээ орон сууцын. Бид нар ингээд 6 хувийн зээл, ипотекийн зээл яваад байдаг АНУ-д өнөөдөр ипотекийн зээл 6 хувьтай байна шүү дээ доллароор. Тэгэхэд бид нар Монгол Улсад төгрөгөөр 6 хувийн зээл байгаа. Энд тийм хэмжээгээрээ Монголбанк өөрөө тэр хэмжээгээрээ алдагдал хүлээж байгаа юм. Нөгөө талдаа үнийн хөөсрөлтийг бий болгоод байна гээд Алдаржавхлан гишүүний яриад байгаа үнэн, бодитой байхгүй юу. Тэгэхээр бид нар энийг зах зээлийн ханш руу нь аваачихын тулд яах ёстой юм бэ гэдэг дээр Монголбанк жоохон ийм бие даасан бодлого барих тал руугаа анхаарахгүй бол хэтэрхий Засгийн газрын хөтөлбөрийг хэрэгжүүлээд тэрнийхээ хэмжээнд алдагдал хүлээгээд байна шүү дээ. Тэгвэл тэр алдагдлаа нөхүүлэх төлөвлөгөө.../минут дуусав./

Р.Сэддорж: Хариулт 3 номер Лхагвасүрэн Ерөнхийлөгч

Б.Лхагвасүрэн: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Яах вэ арилжааны банкны хувьд дүрмийн сан буюу тэр эздийн өмч бол олон улсын стандартынхаа дагуу 10 хувиас багагүй байна гээд ингээд заачихсан байгаа. Тэгэхлээр тэнд нэгэнт харилцагчийн мөнгийг татаж аваад, итгэлцэл дээр үйл ажиллагаа явуулдаг учраас зайлшгүй тодорхой хэмжээний дүрмийн сан, өөрийн хөрөнгө шаардаж явдаг. Улс болгонд байдаг Төв банкнуудын хувьд нэгэнт тийм харилцагчийн мөнгө гэдэг ойлголт байхгүй учраас бодлогын институц гэдэг утгаараа дүрмийн сангийн хэмжээ ямар хэмжээнд байх нь харилцан янз янз байгаа. Өөрийн хөрөнгө хасах байна, хасах биш байна гэдэг нь бас харьцангуй бас ойлголт байгаа.

Тэгэхлээр АНУ-ын Төв банк ч гэдэг юм уу, Мексикийн төв банк, ер нь Чехийн төв банк ч гэдэг юм уу бид нэлээн судалгаа хийсэн. Олон төв банкнуудад дандаа ийм хасах баланстай нэлээн алдагдалтай ийм банкнууд байгаа. Тэгэхдээ энэ хасах баланс алдагдалтай энэ бол бодлогын хэрэгжилтэд ямар нэг нөлөө байхгүй. Зүгээр нэр хүндийн л асуудал байгаа юм. Тэгэхлээр бодлогын арга хэмжээгээ хэвийн хэмжээнд явуулах нь балансаасаа.../минут дуусав./

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж дууслаа.

Санхүүгийн тайлан болон Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье.

Бадамсүрэн гишүүнээр тасалъя.

Асуулт би өөрийн Их Хурлын гишүүний хувьд бас асуугаадахъя.

Сая Соронзонболд гишүүн асуусан хуримтлагдсан алдагдал 7 аравны бараг 5 тэрбум юм байна тээ, их наяд их? Тэгэхээр чинь Монгол Улсын төсвийн энэ чинь 1/3 нь юм уу, 1/5 нь тэгээд энэ их алдагдал байгаа юм байна. Энэ алдагдлаа хэзээ дуусгах вэ? Эндээс чинь хамаг юм чинь болоод байгаа юм биш үү гэдэг ийм асуулт байна. Тэгээд энэ их алдагдалтай байгууллага бол аудит дээр дандаа

сөрөг дүгнэлт авна л даа. Энийгээ яг хугацаатай тодорхой хэлээч. Юу нь болохгүй байна, яаж байна гэдэг талаар.

Мөнгөний бодлого 4 номер, 6 номер дээр сууж байна. Энэ тэтгэврийн зээлийг хуучин хэвд нь оруулчихаач л гээд Их Хурлын гишүүд, тойргоос сонгогдсон гишүүд тэгж хэлээд байгаа юм. Тэгэхээр тэтгэврийн зээлээр битгий оролдоод байгаа. Энэ хүнд үед. Хүнд үе гэж та бүхэн хэлээд байгаа шүү дээ. Хүнд үнэхээр хүнд байна. Тэгэхээр энэ дээр хуучин хэвд нь оруулчихаж болохгүй юу? Заавал ингээд л өөрчлөлт оруулаад, заавал чангалах гээд ингээд байдаг нь ямар учиртай юм бэ? Ер нь тэтгэврийг бараг л хэдхэн зарим хүмүүс л ярьж байгаа даа хүүхдэд, ач зээ нартаа тэтгэвэр өгөхөө тэр настан буурлууд өөрөө мэднэ дээ. Заавал ингээд бүх мөнгөө ингэжээд байна гээд тийм зүйл дээр ингэж оролцоод байх ер нь шаардлага байна уу?

Дээрээс нь Монголбанкны дараагийн нэмэлт, өөрчлөлт хууль Төв банкны хууль дээр байгаа юу? Юун дээр байгаа вэ нөгөө СӨХ-ны компани, гар утасны тусдаа компаниуд аж ахуй нэгжүүдтэй Монголбанкны зээлийн мэдээллийн санг ингээд холбоод сүлжээгээр холбоод хаячихсан. Энийгээ сая Батшугар гишүүний оруулж ирсэн хуулийг Эдийн засгийн байнгын хороо бид бүхэн сайн дэмжиж Улсын Их Хурлаар батлагдсан. Байнгын хороон дээр их дэмжлэг авч, гишүүд их дэмжсэн. Тэгэхээр дараагийн сүлжээг яаж байхгүй болгох бэ энэ дээр ийм 3 асуулт байна.

3 номер.

Б.Лхагвасүрэн: Сэддорж гишүүний асуултад хариулъя. Нийт 7.4 их наяд төгрөгийн хуримтлагдсан алдагдал бол Монголбанк 1991 онд байгуулагдсанаас хойш ингээд үйл ажиллагаа дээр нь гарч байсан орлого, зарлага энэ бүх юмны юмнаас эхлээд явж байгаа. Дийлэнх гол хэсэг нь 2012 оноос эхэлсэн байдаг. 7.4 их наядын энэ алдагдал юунаас үүссэн бэ гэдэг дээр мэдээж Монголбанк дээр тооцоо, судалгаа, бүх юмнууд байж байгаа. 66 хувь нь төв банкны үнэт цаасны хүүгийн зардал байгаа. Эндээс үүссэн алдагдал. Тэгэхээр төв банкны үнэт цаасны хүү гэдэг бол макро эдийн засгийн тогтвортой байлгах үүднээс гаргаж байгаа бодлогын зардал гэж тайлбарлагддаг олон улсад. Өнөөдөр бол төв банкны үнэт цаас дээр 8 их наяд төгрөг ингээд блоклогдоод байж байгаа. Одоо 12 хувийн хүү төлөөд сууж байгаа гэсэн үг.

Хэрвээ энэ төв банкны үнэт цаасыг гаргаагүй энэ 8 их наяд өөрөө эдийн засаг дээрээ хэрэглэгдэх ёстой гэх юм бол энэ хэмжээний мөнгөний нийлүүлэлт бий болно. Энэ хэмжээгээрээ эдийн засагт маш эрсдэлтэй, цочмог зүйл болох учраас төв банк өөрөө энийг өөр дээрээ блоклоод бодлогын зардал гаргаад сууж байгаа гэж хэлж болно. Мөн Монгол Улсад орж ирж байгаа энэ валют байна экспортын, нүүрсний компаниудын орж ирсэн валют юм уу зэсийн Эрдэнэт үйлдвэрийн, Оюу толгойн орж ирж байгаа энэ орлогууд бол өөрөө Монгол Улсад орж ирээд Монголбанктай своп хэлэлцээ, эс үгүй бол арилжаа хийгддэг. Энийгээ зөрөөд төгрөг бол эдийн засаг руу нийлүүлэгдэж байдаг. Энэ нийлүүлэгдсэн төгрөгийг эргээд тогтвортой хэвийн хэмжээнд нь байлгах, юмтай зүйрлэх юм бол үерийн ус шиг биш хөрсөндөө зөв шингэдэг хэмжээгээр байлгах үүднээс энэ төв банкны үнэт цаас ажиллаад хэвийн хэмжээнд нь макро эдийн засгийг тогтвортой байлгах шаардлага гарч байгаа юм.

Тэгэхээр төв банкны үнэт цаасны энэ хэмжээг хэвийн хэмжээнд байлгахын тулд төсвөөр дамжиж их эдийн засаг руу том зардал гарахгүй байвал төв банк дээр энэ бодлогын хүүгийн зардал гарахгүй дарамт бага байна гэж шууд хэлж болохоор байгаа юм.

Тэтгэврийн зээлтэйгээр холбоотойгоор ер нь тэтгэврийн зээл хэрэглээний зээл байгаа. Сүүлд Мөнгөний бодлогын хороо 3 сард гаргасан шийдвэрээрээ тэтгэврийн зээл дээр амьжиргааны баталгаажих доод түвшин буюу 470 мянган төгрөгөөс доош зээлээ төлөөд үлдэх мөнгө нь ийм хэмжээний мөнгө үлдэх ёстой гэдгээрээ ингээ бодлогын макро зохистой шийдвэр гаргасан юм. Тэгэхдээ энэ нь өөрөө өнөөдөр нэлээн төвөгтэй байдал үүсгэж байгаа учраас одоо 6 сард хуралдах Мөнгөний бодлогын хороогоороо тэтгэврийн зээл дээр авсан арга хэмжээгээ бусад хэрэглээний зээлтэй адилтгах маягаар буцаах ийм бодлогын саналыг одоо дэвшүүлээд явж байгаа. Тэгэхээр энэ .../минут дуусав./

Р.Сэддорж: 4 номер.

Н.Батнасан: Сэддорж гишүүний хэлж байгаа зүйлийг бид анхааралдаа авъя. Тэгэхдээ энд бодолцож үзэх 2,3-н зүйл байгаа юм.

Нэгдүгээрт, ерөнхийдөө олон улсын жишгээр харах юм бол тэтгэврийн зээл өгдөг орнууд байна. Тэрний өр, орлогын харьцаа нь 60-70 орчим хувьтай байгаа юм. Гэтэл манай дээр байгаа энэ харьцааг үзэхээр 85 хувьд хүрчхээд байгаа юм. Өөрөөр хэлбэл тэтгэвэр авч байгаа хүний амьдрах эрх нь зөрчигдөх тийм асуудал үүсчхээд байгаа юм. Үүнийг нэгдүгээр харж үзэх хэрэгтэй байна.

Хоёрдугаарт, хэрэглээний зээлүүд дотроос хамгийн эрсдэлтэй бүлэг бол энэ хэсэг байгаа. Хэрвээ бид нар энэ хэсгийг замбараагүй нэмэгдүүлэх юм бол бас банкны салбар дээр чинь эрсдэл үүсээд тэр нь бас зээлийн хүү энэ тэртэй урт хугацаандаа нөлөөлөх юм байгаа.

Гуравдугаарт, бид бол урд нь тэглэх тийм арга хэмжээ авсан энэ бол одоо тэтгэврийн зээл авах тэр сэдлийг нэлээн нэмэгдүүлсэн юм болов уу гэж бодож байгаа.

Р.Сэддорж: 4 номер гүйцээж хариулах уу?

Н.Батнасан: Тийм учраас бид нар тэтгэврийн зээлээ олгоно. Олгохдоо одоогийн нөхцөлийг нь арай дээрдүүлээд гэхдээ хуучин шиг нь явуулах юм бол бас замбараагүй нэмэгдэх тийм эрсдэл байгаа учраас тэрийг бас бодолцож л шийдвэрээ гаргаж таарах байх. Тэр дээр ер нь тооцоо хийж байж л шийдвэрээ гаргана гэсэн иймэрхүү юутай байгаа.

Р.Сэддорж: 6 номер хариулах уу?

Р.Даваадорж: Саяны Сэддорж гишүүний асуултад Монголбанкны Ерөнхийлөгч ерөнхийдөө хариулчих шиг боллоо. Одоо энэ 6 сард бид нарын ээлжит хурал болох юм энэ дээр бид нар авч хэлэлцэнэ. Тэн дээр нэлээн тооцоо судалгаатай тоо баримтууд орж ирдэг юм байна лээ. Тэгээд энийг бид нар тал талаас нь авч ярилцаад шийдвэр гаргачих байх аа гэж бодож байна.

Р.Сэддорж: Хамгийн гол нь тэтгэврийн зээлээр өөр бусад алдагдлаа нөхөх юман дээр л толгойгоо сайн ажиллуулах хэрэгтэй байна. Хамгийн найдвартай аваад сурчихсан зээлээр нь энэ хүнд үед ингээд оролдоод байх ямар шаардлага байна? Эсвэл яах гэж анхнаасаа тэтгэврийн зээл гэдэг зүйлийг Монголбанкны залгамж чанар гэж байдаг биз дээ? Энэ бодлогын залгамж чанар байх ёстой. Төрийн бодлогын залгамж халаа гэж байдаг шүү дээ. Тэр шиг энэ зүйл дээрээ та хэд сайн бодолцоно биз дээ. Хөдөө аймгуудаар уулзалт хийхэд ийм л юм ярьж байна шүү дээ. Тэрүүгээр битгий оролдооч дээ, хуучин хивэнд байлгачхаач дээ л гэж байгаа юм. Шууд нөлөөлж болохгүй байх л даа та бүхэнд. 6 сард хуралдах хурлыг л хүлээж байя.

Ингээд үг хэлж эхэлье. Энхтүвшин гишүүн үг хэлнэ.

Д.Энхтүвшин: Байнгын хорооны гишүүддээ нэг юмыг энэ Хяналтын зөвлөлөөс өгсөн дүгнэлттэй холбоотой 2.1.3 дээр байгаа энэ заалтыг онцгойлж саналаа, энийг онцгойлж анхаарах хэрэгтэй юм байна гэдэг талаар бас байр сууриа илэрхийлье гэж бодож байна. Ер нь өнгөрсөн хугацаанд мэдээж Монголбанкны бие даасан байдал чухал. Гэхдээ энд өөрөө Улсын Их Хурал маань санхүүгийн үр дагавартай шийдвэрүүдийг, даалгавруудыг гаргаж өгснөөрөө бие даасан байдалд нь халдаж байгаа байсан, өнгөрсөн хугацаанд ийм үр дүнгүүд гарч ирсэн. Хэрэв цаашдаа хэдүүлээ бас мэргэжлийн Байнгын хорооны хувьд ч гэсэн аль болох санхүүгийн үр дүнтэй энэ чиглэлүүд Улсын Их Хурал руу оруулж ирэхгүй Байнгын хороогоор энийг давуулахгүй байх тал дээрээ хэдүүлээ бас анхаарч ажиллая гэж Байнгын хорооныхоо гишүүдэд хэлмээр байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Бадамсүрэн гишүүн үг хэлнэ.

М.Бадамсүрэн: Би тодорхой 3 санал хэлэх гэсэн юм. Тойрогт ажиллахад өндөр настны зээлийг шууд сард үлдэх хэмжээг хязгаарласантай холбоотой гомдлууд их гараад байгаа юм. Тэгэхээр тодорхой хэмжээнд амьжиргааны шаардагдах тэтгэврийн мөнгө тэр хүнд ирдэг байх гэдэг нь зөв. Гэхдээ та бүхний авч хэрэгжүүлсэн арга хэмжээ бол шууд аваад хэрэгжүүлсэн байхгүй юу. 480 мянган төгрөг заавал үлдэнэ гээд. Зүй нь жилд ингээд 4 жилийн хугацаанд энийгээ үе шаттай хэрэгжүүлэх ёстой байхгүй юу. Эхний жилд 100 мянгаар тавиад, 26 оны дахиад 100 мянга нэмэгдээд 200 мянга заавал үлдэх юм шүү. 27 онд 300 мянга заавал үлдэх юм шүү гээд. Ер ингээд юмыг чинь ингээд аажмаар дасгадаг шүү дээ. Температурт ч гэсэн хүнийг чинь аажмаар дасгадаг. Ийм бодлого барихгүй гэнэтийн цохилт өгсөн шийдвэрүүдийг огцом гарахаар тэр хүний эрх ашигт шууд нөлөөлөөд байгаа байхгүй юу. Тэгэхээр зөв бодлого үе шаттайгаар явах. Танай Мөнгөний бодлогын зөвлөл яг хуралдахдаа энийг анхаарч гэсэн санал байна. Нэг.

Хоёр нь инфляцыг бууруулах чиглэлээр жоохон бие даасан үйл ажиллагаа явуулах дээрээ зоригтой ажиллах хэрэгтэй гэдгийг олон гишүүд бас хэлж байна. Ер нь бол. Ингээд дундаа аливаа зүйл эзэнгүйдэхгүй байх ёстой. Тэгэхээр би ямар санал хэлэх гээд тэгэхээр тодорхой санал хэлж байгаа юм. Дотоодод мөнгөний дутагдал, зээлийн эх үүсвэрийн дутагдал тэртээ тэргүй байна. Та бүх мөнгөний нийлүүлэлтийг багасгана гээд яриад байна. Энэ чинь өөр олон янз, хэрэглээнд байгаа эргэлдэх мөнгийг хязгаарлах чинь нэг бодлого. Нөгөө талдаа Алдаржавхлан гишүүн хэлсэн ипотекийн зээлийн зүй бол ипотекийн зээл гарч байгаа нь 6 хувийн хүүтэй байх юм бол энэ орон сууцын барьдаг жижиг, дунд компаниудад зориулж 6 хувийн хүүтэй зээл олгож энэ хоёрын чинь хүү ижил байх

юм бол энийг чинь үнийн өсөлтөөс хязгаарлах, орон сууцын барих бодлогыг дэмжих ийм гол зохицуулалт болно шүү дээ. Нэг.

Хоёрт нь яг энэнтэй адилхан дотоодын ЖДҮ-лэл үндэсний үйлдвэрүүд буюу импортыг орлох, экспортыг дэмжих шинж чанартай энэ үндэсний үйлдвэрүүдэд хөнгөлөлттэй зээлийн хэрэгцээ маш дутагдалтай байна.

Тийм учраас банк бусаас зээл авч байна. Сандраад орон сууц нь дуусах гээд ашиглалтад орох гээд байдаг, комисс ажиллах гээд байдаг, улсын комисс. Тэр үед нь яадаг вэ гэхээр сандраад банк бусаас зээл авдаг нууц биш. Ийм олон барилгын бизнесмен байна. Тэр мөнгө хаана шингэх вэ гэхээр метр квадратынхаа үнэдээ шингэж байгаа юм.

Тэгэхээр энийг өсгөхгүй байх бодлого чинь өөрөө том макро түвшний хувьд иргэдийн амьжиргаанд зээл төлөлтөд хүүгийн хэмжээнд шууд нөлөөлж байгаа энэ арга хэмжээг цогцоор нь авч үзээч л гэдэг саналыг хэлээд байгаа юм л даа. Энэ дээр та бүхэн маш сайн ийм зөв, оновчтой бодлогыг хэрэгжүүлж, гаргаж өгч юунд танилцуулаач.

Дараагийнх нь танай оролцоотойгоор бас энэ инфляцыг буруу чиглэлээр хэрэгжүүлэх бас арга хэмжээ байна. Иргэдийн хадгаламжийг яаж эргэлтэд оруулах юм? Энэ тал дээр ямар оновчтой бодлого хэрэгжүүлж байгаа юм бэ? Энэ хадгаламжид ноогдуулж байгаа татвартай холбоотой бодлого байдаг юм уу? Яг мэргэжлийн энэ төв банкны хувьд ямар бодлого хэрэгжүүлдэг юм? Энэ дээр та бүхэн бас анхаарч өгч ийм хадгаламжаа эргэлтэд оруулалтынх нь тийм хөшүүрэг энэ зүйлүүдийг илүү сайн хэрэгжүүлж өгөөч гэсэн.

Хамгийн сүүлийнх нь ер нь энэ манай Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд энэ эдийн засгийн гол ялангуяа энэ макро түвшний эдийн засгийн бодлогууд, энэ мөнгөний бодлогууд гээд энэ зүйлүүдэд хамаардаг учраас энэ инфляцтай хэрхэн бууруулах чиглэлээр тэмцэж байгаа юм бэ? Ямар бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж байгаа гэдэг талаар. Нэг.

Хоёрт нь Үндэсний баялгийн сангийн хөрөнгийг нь яаж зарцуулж байгаа гэдэг талаар ийм хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулж ажиллуулж өгөөч гэсэн саналыг бас Байнгын хорооны даргадаа дэвшүүлж байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Жуковын Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Би Лхагвасүрэн Ерөнхийлөгч тэр төсвийн зарлагатай холбоотой саналаа та бүгд 9 дүгээр сар гэхэд л Байнгын хороонд өгмөөр байна. Бүр албан ёсоор. Та нар Засгийн газарт санал өгдөг шүү дээ. Яг тэрийг чинь Эдийн засгийн байнгын хороонд өгөөд ер нь ирэх оны төсвийн зарлагыг төдий хэмжээгээр өсгөвөл болохоор байна, төлбөрийн тэнцэл тээвэр хавьд байвал болохоор байна гэсэн балансаа энэ тэр бид нарт гаргаад өгчих юм бол ядаж бид нар нөгөө Засгийн газарт чиглэл өгөх бололцоо Их Хуралд байгаа байхгүй юу. Та нарыг тоохгүй бол бид нар эндээс чиглэл өгөх. Тэгэхгүй бол ирэх жил манай Жавхлан сайд чинь дахиад хэдэн их наядаар зарлагаа нэмэгдүүлэх нь мэдэгдэхгүй байгаа шүү дээ. Орлого нь байхгүй байхад зарлагаа нэмэгдүүлээд байдаг.

Хоёрдугаарт нь би ийм ажлын хэсэг гаргаж ажиллахаар бас сая Байнгын хорооны даргатай ярилаа. Ипотекийн зээлийн өнөөгийн нөхцөл байдал, орон сууцын үнийн өсөлтийн бодит байдлыг судлан үзэж танилцуулах ажлын хэсэг байгуулъя гэж бас Байнгын хорооны даргад хэлсэн. Тэгээд манай Монголбанкныхан маань бас та хэд бас сайн оролцоорой. Тэр ялангуяа тэр Хяналтын зөвлөлийн дарга их эрчтэй хүн байгаа шүү. Чи тэр орж хамтарч ажиллана шүү. Хэн билээ манай Хяналтын зөвлөлийн дарга чинь? Ууганбаатар чи тэрэнд заавал орж ажиллуулна.

Хэдүүлээ энэ бас ипотекийн зээлийн асуудлуудаар сайхан хамтарч ажиллаад орон сууцын бодит өсөлтийн асуудал дээр ямар байгаа манай Байнгын хороон дээр ажлын хэсэг гаргаад хэдүүлээ ажиллая гэсэн ийм бодолтой байгаа. Ийм саналтай байна.

Р.Сэддорж: Соронзонболд гишүүн үг хэлнэ.

Л.Соронзонболд: Монголбанкн дээр энэ Засгийн газрын хөтөлбөрт оролцоод түүнийг хэрэгжүүлэхдээ гарч байгаа энэ алдагдал гарч ирж байгаа. Тэгэхээр тэр алдагдлыг анхнаасаа хөтөлбөрт орохдоо энэ ямар хугацаанд яаж барагдуулах вэ гэдэг ийм төлөвлөгөөтэй ажилладаг болмоор байна гэдэг ийм чиглэл өгмөөр байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт болохоор энэ жил болгон мөнгөний бодлогын чиглэл батлуулдаг. Тэгэхдээ ер нь энэ төсвийн хүрээний мэдэгдэлтэй адилхан бас Монголбанкны баланс, алдагдал ер нь ойролцоогоор бодлогын хүрээнд зардал нь хэд болох гээд байгаа юм, баланс чинь хэд болох гээд байгаа юм гэдэг иймэрхүү чиглэлтэй болохгүй бол ингээд хэдүүлээ ингээд чөлөөтэй алдагдал хийж болно гээд ингээд яваад байж бас болохгүй байх гээд байхгүй юу. Энэ Америк, Энэтхэгийн төв банкнууд чинь улсдаа мөнгө өгөөд байгаа шүү дээ ашиг хийгээд. Тэгээд тэрийг нь төсөвт нь өгөөд байгаа байхгүй юу. Тэгвэл бид нар ингээд л алдагдал хийдэг юм гэдэг байдлаар ингээд яваад байж болохгүй гэдэг ийм юу байна.

Дараа нь нөгөө талдаа болохоор манай энэ Монголбанк статистик энэ чадамж их сайтай. Гэхдээ ингээд яг ийм тодорхой ийм бодлогын судалгаа авах гэхээр бас ингээд мэдээлэлд ингээд хариулж өгч чадахгүй ийм асуудал харагдаад байгаа. Ялангуяа ингээд мөнгөний нийлүүлэлттэй холбоотой, ийм зээлтэй холбоотой яг Монгол Улсын 2024 оны ДНБ-ийг нэмэгдүүлэхэд гарсан зээлийн олголт хэд юм бэ гээд л асуухаар хариулж чадахгүй. Иймэрхүү чиглэл рүү жоохон нарийсмаар байна гээд байхгүй юу. Илүү мэргэшсэн ийм чиглэл рүү энэ статистик мэдээллээ энэ цуглуулж авдаг болох тал руугаа хандмаар байна гэж хэлмээр байгаа юм.

Дараа нь болохоор бид нар ингээд уул уурхайн салбар хамарсан эдийн засагтай улс үнэхээр ялт ч байхгүй энийгээ дагаад циклээ дагаж байна. Тэгэхдээ Монголбанк бас энэ алтны экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр бас ингээд бодлогоор ингээд дэмжээд явдаг. Энэ хүрээндээ бас гаднын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтарч ажилладаг. Тэгэхээр энэ үйл ажиллагаагаа бас цаашдаа өргөжүүлэх тал дээр бас нэлээн ажлууд хийх ёстой байх гэж бодож байгаа. Яах вэ зүгээр би танай тайланг харахаар ер нь энэ алтны чиглэлээр гадаадын банк, санхүүгийн байгууллагатай хийсэн гэрээ, хэлцэл нь ганц, хоёр банктай л хийсэн юм байна лээ.

Цаашдаа энийгээ жоохон өргөжүүлэх тал дээр анхаармаар юм шиг санагдаад байгаа. Тийм учраас энэ дээр анхаарч ажиллаарай гэж хэлмээр байна. Тэгээд 2026 оны төсөв дээр ер нь Монголбанкны дүрмийн санг нэмэгдүүлэх талаар эргээд тодорхой санал гаргаад тэгээд тэр дээр Сангийн яамтай хэд байдаг юм 200, 300 тэрбум байдаг юм уу, 500 тэрбум байдаг юм уу ийм тодорхой санал солилцож энэ бичгээ явуулах ёстой байх л гэж бодож байна. Энэ дээр Монголбанк ажил хийх ёстой.

Р.Сэддорж: Нэг асуултад хариулсангүй дээ түрүүн тээ? Тэр дараагийн хууль хэзээ орж ирэх вэ, хэн оруулж ирэх ёстой вэ? Хуулийн өөрчлөлт орж ирэх үү, дургүй байгаа юу? Зээлийн мэдээлэл сан дээр л баахан яригдсан шүү дээ тээ? 3 номер.

Б.Лхагвасүрэн: Төв банкны хууль хамгийн сүүлд 2019 онд нэмэлт, өөрчлөлт орсон байгаа. Дараагийн нэмэлт, өөрчлөлт оруулах ийм хуулийн судалгаа нэмэлт, өөрчлөлт оруулах тодорхой хэмжээний төсөл, саналууд бол бэлэн бэлтгэгдэж байгаа. Мөн Олон улсын валютын сангаас бас манай энэ бэлтгэж байгаа санал дээр зөвлөгөө өгье гэдгээрээ бас техник, туслалцаа үзүүлээд ийм 2 мэргэжилтнийг бас томилоод ажиллуулж байгаа. Тухайн 2 мэргэжилтнээс эцсийн байдлаар хариу нь гарч ирээгүй байгаа.

Тэгэхлээр энэ энэ дээр Олон улсын валютын сангийн бас зөвлөмжийг тусгачихвал хуулийн төсөл ерөнхийдөө нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл бэлэн болно. Тэр утгаараа тэгээд Монголбанканд хууль өргөн барих эрх байхгүй. Тэгэхлээр манай Эдийн засгийн байнгын хорооны аль нэг гишүүнээр хуулийг өргөн бариулах боломжтой гэж харж байгаа.

Р.Сэддорж: Гишүүд үг хэлж дууслаа. 2 гишүүнээс санал ирсэн байна. Монголбанкны мэдээлэл сонссонтой холбогдуулан Монголбанканд дахь Ирээдүйн өв сангийн валют болон тус банкны Төрийн сангийн данс дахь хуримтлал, Хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, гүйцэтгэл болон Үндэсний баялгийн сангийн хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцаж, холбогдох санал, дүгнэлт гаргах шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах саналыг Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн гаргасан байна. Ажлын хэсэгт Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал, Жаргалан, Батчимэг, Бадамсүрэн, Энхтүвшин гэсэн ийм 5 гишүүн орохоор саналаа ирүүлсэн байна.

Мөн Алдаржавхлан гишүүнээс Ипотекийн зээлийн хэрэгжилтийг хянан шалгах ажлын хэсэг байгуулъя гэсэн ийм хүсэлт ирсэн. Ийм учраас энэ 2 саналаар санал хураа. Энэ 2 ажлын хэсэг байгуулах тус бүрд нь санал хураана.

Нэгдүгээрт нь Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэнгийн гаргасан ажлын хэсгийг байгуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураана. Гишүүд санал хураалтад бэлдье.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэнгийн гаргасан хянан шалгах ажлын хэсэг байгуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлангийн гаргасан саналаар хянан шалгах ажлын хэсэг байгуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Алдаржавхлан гишүүний ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Алдаржавхлан гишүүн хэлчих.

Дараагийн Байнгын хорооны хурлаар бүрэлдэхүүн болон удирдамжийг баталъя. Соронзон гишүүн болчихсон тээ?

Монголбанкны 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан болон Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийг хэлэлцэж дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж байна. Хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаа идэвхтэй оролцсон гишүүдээ баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа.

16.43 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР